

Гадаадын иргэн, харьяатын газрын
2022 оны ...дугаар сарын ...-ны өдрийн
..... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2022.01.01-2022.12.10/

2022 оны 12 дугаар сарын 14

Улаанбаатар хот

1	2	3	4	5	6	7	8
Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги зорилго 1. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх /Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.3.9/, Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ. /Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 5.2/, Алсын хараа-2050 2.7.4							
Зорилт 1. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний гуравдугаар зорилт)							
1	Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Go travel” хөтөлбөр буюу Зорчигчдын урьдчилсан мэдээллийн дэвшилтэт системийг Монгол Улсад нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх	Терроризм той тэмцэх зөвлөлийн санхүүжил тээр	- Оролцсон ажлын хэсгийн тоо; - Оролцсон хурал, сургалтын тоо, огноо; - Оролцсон албан хаагчийн тоо, мэдээлэл;	Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор Нэгдсэн Үндэстний байгууллагын “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр /Go Travel/-ийг хэрэгжүүлэх, энэ талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон. Тус хөтөлбөрийг зохицуулагч	Эхний хагас жил, жилийн эцэст: Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ажлын хэсгээс гаргасан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд оролцож, мэдээ,	Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолын дагуу НҮБ-ын “Go travel” буюу “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэт систем”-ийг Монгол Улсад нутагшуулах, нэвтрүүлэх ажлыг Терроризмтой тэмцэх зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус байгууллагаас дэд ажлын хэсгүүдэд нийт 4 албан хаагч ажиллаж байна.	100

1	2	3	4	5	6	7	8
			Боловсруул сан санал, мэдээлэл.	байгууллагаар Хил хамгаалах ерөнхий газар, үндсэн зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хариуцуулсан. Тус байгууллагаас хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлын хэсэгт Виз, зөвшөөрлийн газрын дарга, Агаарын замын боомт хариуцсан газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар оролцож, чиглэл бүрийн ажлын хэсэгт 4 албан хаагч томилогдон ажиллаж байна.	мэдээллээр хангасан байна.	<p>“Зорчигчийн мэдээллийн төвийн үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий “Хууль эрх зүйн дэд ажлын хэсэг”-ийн 04-06 дугаар сард зохион байгуулсан нийт 4 удаагийн хуралдаанаар журмын төсөлд тусгах санал, хууль эрх зүйн өөрчлөлтийн талаар эцсийн хувилбарыг хэлэлцүүлэхэд, холбогдох саналыг тусгаж, эцсийн хувилбарыг НҮБ-ын экспертийн багт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.</p> <p>“Зорчигчийн мэдээллийн төв”-ийн ашиглах мэдээллийн сангийн хяналтын жагсаалтыг боловсруулах, уг мэдээллийн сангаас гарсан үр дүнтэй танилцах эрх бүхий албан тушаалтныг тодорхойлох зорилгоор “Үйл ажиллагааны дэд ажлын хэсэг”-т өөрийн байгууллагын одоогийн ашиглаж буй мэдээллийн сангийн талаар болон “Зорчигчийн мэдээллийн төв”-тэй солилцох мэдээллийн төрлийн талаар товч танилцуулгыг боловсруулж, танилцуулсан.</p> <p>“Зорчигчийн мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааны чиг үүрэгт тавигдах шаардлага”, зам зураглал, таск листийг үндэслэж төлөвлөсөн загварын 2 дугаар хувилбар болох “Зорчигчийн мэдээллийн төв”-д зайлшгүй ажиллах байгууллагын жагсаалтад Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Терроризмтой тэмцэх зөвлөлийг хамааруулж, шаардлагатай тохиолдолд Авлигатай</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>тэмцэх газар, Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба ажиллахаар тогтож, “Зорчигчийн мэдээллийн төв”-ийн бүтэц, орон тооны төсөөллийг боловсрууллаа.</p> <p>“Техникийн дэд ажлын хэсэг”-ийн гишүүд 10 дугаар сарын 01-ний өдөр НҮБ-ын “Golearn” сургалтын платформоор хөтөлбөртэй холбоотой сургалтад цахим хэлбэрээр хамрагдаж, сертификат гардсан.</p> <p>“Техникийн дэд ажлын хэсэг”-ийн талуудын оролцоо болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг 01 дүгээр сарын 18-ны өдөр, тоног төхөөрөмжийн үнийн судалгаанд аж ахуйн нэгжээс судалсан сервер, сторижийн үнийн саналыг 10 дугаар сарын 19-ний өдөр тус тус Терроризмтой тэмцэх зөвлөлд хүргүүлэв.</p> <p>Терроризмтой тэмцэх зөвлөлийн даргын 02 дугаар сарын 22-ны өдрийн А/02 дугаар тушаал болон Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах “Хаан шонхор 2022” нэгдсэн дадлага сургуулийн ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу “Хүн, агаарын хөлөг барьцаалсан террорист үйлдлийн үед сөрөг тусгай ажиллагаа явуулах террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх”, “Тээврийн хэрэгсэл ашигласан болон тээврийн хэрэгслээр террорист халдлага үйлдсэн үеийн сөрөг тусгай ажиллагаа явуулах нь” сэдэвт дадлага сургуулилтад 03 дугаар сарын 09-өөс 12-ны өдрүүдэд Хяналт-шинжилгээ,</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>үнэлгээ, аудитын хэлтсийн дарга хамрагдав. Мөн Терроризмтой тэмцэх зөвлөлийн албан уулзалтад 02 дугаар сарын 15-ны өдөр, 1 дүгээр улирлын хуралдаанд 03 дугаар сарын 24-ний өдөр тус тус оролцлоо.</p> <p>“Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд “Ажлын хэсэг”-ээс тусгах саналыг 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/2053 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.</p>	
2	<p>Монгол Улсад ирж буй гадаад иргэдийг цахимаар бүртгэх буюу гар утасны мессеж (sms) үйлчилгээ ашиглан бүртгэх ажлыг зохион байгуулах</p>	45 сая төгрөг	<ul style="list-style-type: none"> - Тендер шалгаруулалтын дугаар, шалгарсан компанитай хийсэн гэрээ; - Мессеж бүртгэлийн программ нэвтрүүлсэн огноо. 	<p>2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр байгуулан APP Store, Play Store дээрх хувилбарыг 09 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн бүрэн оруулсан. Тус аппликейшныг ашиглан гадаадын иргэдийг бүртгүүлэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сүүлийн үеийн шинэ мэдээ, мэдээлэл авах боломжтой болсон. Мөн “E-Immigration” аппликейшн англи, орос, хятад, солонгос гэсэн 4 хэлний сонголттойгоор бүтээгдсэн бөгөөд бүртгэл хийж эхэлснээс хойш тайлант хугацаанд</p>	<p>Эхний хагас жилд: Программ хангамж хөгжүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан компанитай гэрээ байгуулах, гэрээний дагуу хөгжүүлэлтийг хийж эхэлсэн байна. Жилийн эцэст: Программыг туршиж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.</p>	<p>Программ хангамж хөгжүүлэх зах зээлийн өртөг өссөн, батлагдсан төсөв бодит өртөгтэй нийцэхгүйн улмаас “Мэдээлэл технологийн үйлчилгээний багц” 2 дугаар бүхий 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарласан.</p> <p>Сонгон шалгаруулалтаар “Лидер вишн групп” ХХК шалгарсан бөгөөд “Аверс секьюрити” ХХК-аас Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газарт гомдол гаргаснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан холбогдох материалуудыг 03 дугаар сарын 23-ны өдрийн 01/565 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Гомдлын дагуу Сангийн яамнаас тус тендерийг дахин үнэлэх тухай чиглэл</p>	70

1	2	3	4	5	6	7	8
				219 иргэн бүртгэл хийлгэсэн байна.		ирүүлсэн боловч төсвийн тодотголоор дээрх төсөв хасагдсантай холбогдуулан тус тендерийг цуцалсан байна.	
3	Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, нэвтрүүлэх	470 сая төгрөг	- Программ хангамжийн хөгжүүлэлтэд хэрэглэгчийн шаардлагыг хүргүүлсэн огноо; Программыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн огноо.	“Визийн мэдээллийн нэгдсэн сан” төсөл 05 дугаар сараас эхлэн тус байгууллага дээр хэрэгжиж эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр “Интерактив” ХХК шалгарч 2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар цахим визийн evisa.mn сайтаар дамжуулан визийн хүсэлтийг хүлээн авах эхний хувилбарыг, 10 дугаар сарын 01-ээс үндсэн ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.	Эхний хагас жилд: Программыг хийж гүйцэтгэх байгууллагыг олж, хэрэглэгчийн шаардлагыг боловсруулан программ хөгжүүлэгчид хүргүүлж хөгжүүлэлтийг хийж, боломжит туршилт тестийг хийсэн байна. Жилийн эцэст: Программын хөгжүүлэлтийг хийн, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	“Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр төлөвлөн хөгжүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр 04 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулж, хөгжүүлэлтийг эхлүүлсэн боловч, гүйцэтгэлийн үр дүнгээр систем хөгжүүлэлт хангалтгүй үндэслэлээр 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/1391 дүгээр албан бичгээр “Гэрээг системс ХХК”-д мэдэгдэл хүргүүлж, гэрээг цуцалсан. Тус программ хангамжийн гүйцэтгэгчийг дахин сонгон шалгаруулж, 10 дугаар сард захиалагч, гүйцэтгэгч 2 талын харилцан тохиролцооноор ажил гүйцэтгэх гэрээг байгуулан 11 дүгээр сарын 18-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж 12 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулж ирүүлжээ. Байгууллагын даргын тушаалаар байгуулсан “Ажлын хэсэг”-ээс “Гадаадын иргэний оршин суух бүртгэл, хяналт, үнэмлэх хэвлэх программ хангамжийн ажил гүйцэтгэх” 01/10-74 дүгээр гэрээний хэрэгжилт,	100

1	2	3	4	5	6	7	8
						гүйцэтгэлд үнэлгээ хийж, гэрээний хавсралтад заасан ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар санхүүжилтийг 100 хувь олгож, тус программ хангамжийг туршилтаар нэвтрүүлээд байна.	
4	Оршин суух зөвшөөрлийн сунгалтын хүсэлтийг цахимаар хүлээж авах	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Холбогдох зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн хөгжүүлэлтийн санал, түүний дагуу хийгдсэн хөгжүүлэлт, түүний огноо; - Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн огноо. 	2021 оны 12 сарын 01-ний өдрөөс бүх төрлийн визийн зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.	Эхний хагас жилд: Холбогдох зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн албан ёсны саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт сайжруулалтыг eimmigration.mn-д хийсэн байна. Жилийн эцэст: Үйл ажиллагаанд нэвтрүүлж, жигдэрсэн байна.	Eimmigration системд оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгах, хасах хүсэлт гаргах, цагаачийн гарах-орох мэдэгдлийг хүлээж авах хэсэг, виз сунгуулах хүсэлтийг цахимаар хүлээж авах, иргэн өөрийн оршин суух зөвшөөрлийн мэдээллийг шалгах, тодорхойлолт хэлбэрээр гаргаж авах боломж, шинэ хүсэлт, шийдвэрлэлт бүрийн явцыг талаарх мэдээллийг хүргэх хариу мэйлийн хөгжүүлэлт болон хэрэглэгч шинээр бүртгүүлэхэд Yahoo mail-ээр бүртгэл үүсгэхгүй байх тохиргоо зэрэг 11 дэд ангиллын 56 төрлийн үйлчилгээг нэмж хөгжүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүллээ.	100
5	Байгууллагын үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн удирдлага, өргөдөл гомдлын бүртгэлийн шинэ систем (ERP) нэвтрүүлэх	Улсын төсөв	<ul style="list-style-type: none"> - Системийг нэвтрүүлсэн огноо; Системд холбогдсон зохион байгуулалтын нэгж, албан хаагчийн тоо. 	Байгууллагын даргын 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 01/998 дугаар албан бичгээр (ep.e-mongolia) системд бүртгүүлэх хүсэлтийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн бөгөөд уг ажлын хүрээнд хүний нөөц, мэдээллийн технологийн чиг үүргийг хариуцдаг албан хаагчдыг 2 удаагийн сургалтад хамруулж, 9 дүгээр сарын 01-ний	Эхний хагас жил: Системийг бүрэн үйл ажиллагаанд нэвтрүүлж, үйл ажиллагааг жигдрүүлсэн байна.	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг байгууллагын даргын 03 дугаар сарын 25-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулж, системийг ашиглахтай холбоотой тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/820 дугаар албан бичгээр "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газарт хүсэлт хүргүүлснээр уг системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд үүсэж буй зарим үйлдэлтэй холбоотой доголдлыг завсарлууллаа.	100

1	2	3	4	5	6	7	8
				<p>өдрөөс (erp.e-mongolia.mn) системд 279 албан хаагчийн мэдээллийг бүртгэсэн.</p>		<p>Байгууллагын даргын 06 дугаар сарын 10-ны өдрийн “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” (erp.e-mongolia) ашиглах тухай” А/93 дугаар тушаалыг батлав. Төрийн байгууллага хооронд болон байгууллагын зохион байгуулалтын нэгж хоорондын шуурхай байдлыг хангах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд системийг албан хэрэгцээнд бүрэн нэвтрүүлж, хэрэглээнд хэвшүүлэн байгууллагын даргын А/93 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Зохион байгуулалтын бүх нэгж (16) болон ажиллаж байгаа нийт албан хаагчид (276) бүртгэл үүсгэж, хандах эрхийг нээх болон нэмэгдүүлэх арга хэмжээг авч тогтмол ашиглаж байна.</p>	
6	<p>Оршин суух үнэмлэх хэвлэх программ хангамж хөгжүүлэх</p>	40 сая төгрөг	<ul style="list-style-type: none"> - Хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах; - Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний огноо, дугаар; - Системийн хөгжүүлэлтэд хэрэглэгчийн шаардлага; - Программ хангамжийн 	-	<p>Эхний хагас жилд: Программ хангамж хөгжүүлэх тендер шалгаруулалтад хэрэглэгчийн шаардлагыг эцэслэн боловсруулах, шалгарсан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулсан байна.</p>	<p>Мэдээлэл технологийн үйлчилгээний багц 1, 2 дугаарт “Аверс секьюрити” ХХК-аас Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газарт гомдол гаргаснаар Сангийн яамнаас тус тендерийг дахин үнэлэх тухай чиглэл ирүүлсэн боловч төсвийн тодотголоор дээрх төсөв хасагдсантай холбогдуулан тендерийг цуцалсан. Тендер цуцлагдсан ч оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний мэдээллийг “Оршин суух үнэмлэх хэвлэх программ” (RCP)-д дамжуулах сервис (API)-ийг байгууллага өөрийн нөөц боломжид тулгуурлан шинээр хөгжүүлж, 11 дүгээр сарын 17-ны өдөр ажиллагаанд орууллаа.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
			хөгжүүлэлт, нэвтрүүлсэн хугацаа.		Жилийн эцэст: Программын хөгжүүлэлтийг хийж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (ТИКА)-аас үнэмлэх хэвлэх тоног төхөөрөмж 2 ширхгийг буцалтгүй тусламжаар хүлээн авч, тест хэвлэж бэлтгэв.	
7	Дахин давтагдахгүй бүртгэлийн дугаар олгох программ (Fregister)-ыг холбогдох байгууллагад нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Хур мэдээллийн системд байршуулсан сервис, мэдээллийн огноо; - Холбогдсон байгууллагын нэр, тоо; - Үйлчилгээг нэвтрүүлсэн огноо. 	<p>ГИХГ/202112004 дугаартай “Мэдээлэл технологийн үйлчилгээний” тендер шалгаруулалтыг зохион байгуулж “багц-3” шалгаруулалтад 75,900,000 төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Лидер вишн групп” ХХК шалгарч 01/07-05 дугаартай гэрээг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан.</p> <p>Гэрээний дагуу Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох /RNSF/-ийг 06 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулж тайлант хугацаанд Монгол Улсад өмнө нь байсан болон одоо байгаа нийт 111,716 орчим гадаадын иргэнд регистрийн дугаар олгосон байна.</p>	<p>Эхний хагас жилд: утасны сүлжээний оператор компаниуд, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газартай мэдээлэл солилцдог болсон байна.</p> <p>Жилийн эцэст: Арилжааны банкууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газартай мэдээлэл солилцдог болж, “Emongolia” системд гадаадын иргэд</p>	<p>Тайлант онд “Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем” (RNSF)-ээр нийт 295118 гадаадын иргэнд 13 орон бүхий регистрийн дугаар олгов.</p> <p>Уг системийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системээр дамжуулан үүрэн холбооны 4 оператор компанид хандах эрхийг үүсгэн, Мобиком корпораци ХХК-тай 01/11-48 дугаар, Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газартай 01/011-53 дугаар мэдээлэл харилцан солилцох гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаж байна.</p> <p>Гадаадын иргэний бүртгэлийн дугаар олгох (RNSF) системийн сервисийг Татварын ерөнхий газартай 09 дүгээр сарын 26-ны өдөр, Нийгмийн даатгалын ерөнхий газартай 10 дугаар сарын 25-ны өдөр холбож, тус тус мэдээлэл харилцан солилцож эхлэв.</p> <p>Оршин суух үнэмлэх хэвлэх программ (RCP)-д зориулж RNSF системээс Fregister болон бусад шаардлагатай мэдээллийг дамжуулах сервис үүсгэлээ.</p>	90

1	2	3	4	5	6	7	8
					бүртгэлийн дугаар (Fregister)-аар нэвтрэх боломжийг судалж танилцуулах байна.		
8	Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэнд цахим гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Эрх бүхий байгууллагатай хийсэн гэрээний дугаар, огноо; - Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн огноо. 	-	Эхний хагас жил: Цахим гарын үсгийг зарим ангиллын оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд олгох талаар судалгаа хийсэн байна. Жилийн эцэст: Харилцаа холбооны зохицуулах хорооноос эрх олгосон гэрчилгээжүүлэгч байгууллагатай гэрээ хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Зарим ангиллын оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэнд тоон гарын үсэг олгох асуудлаар судалгаа хийж, дараах нөхцөл байдлыг тодорхойлов. Гадаадын иргэнд олгосон бүртгэлийн дугаар дээр үндэслэн тоон гарын үсгийг олгох ба 2022 онд нийт 295118 иргэнд бүртгэлийн дугаар олгосон байна. Гадаадын иргэнд тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлын хүрээнд E-Mongolia академитай 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан уулзалтаар цахим үйлчилгээний нэгдсэн портал (e-mongolia.mn) системтэй бүртгэлийн дугаар олгох (RNSF) системийг холбож, байгууллагаас гадаадын иргэнд үзүүлж болох үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр хэлэлцэн тохиролцов.	70
9	Виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISM)-ийн мэдээллийн өгөгдлийг цэгцлэх, шинэ “Виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д	Урсгал зардал	- Давхардсан болон алдаатай оруулсан нийт мэдээллийн тоо, илтгэх хуудсаар удирдлагад	2007 оноос хойш системийн шилжилтийг 3 удаа хийсэн бөгөөд үүнээс үүссэн өгөгдлийн санд бий болсон зөрүүтэй мэдээлэл, алдааг цэгцлэх зорилгоор байгууллагын даргын 09 дүгээр сарын	Эхний хагас жилд: Өгөгдлийн сан дахь мэдээлэлд нэг бүрчлэн тулгалт хийж, ангилан, дүнг илтгэх хуудсаар удирдлагад	Гадаадын иргэний виз, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээр хугацаа хэтрүүлсэн 216 улсын 153495 иргэн, харьяалалгүй 877 хүн нийт 154372 гадаадын иргэний мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулан тулгалт хийж, тус улсаас гарсан, хугацаа хэтрүүлсэн мэдээллийг нэгтгэн 10 дугаар сарын 15-ны өдөр	90

1	2	3	4	5	6	7	8
	зөөвөрлөх ажлыг зохион байгуулах		танилцуулсан огноо; - Засварласан мэдээллийн тоо, шийдвэрлэл тийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан.	22-ны өдрийн 01/06-12 дугаартай удирдамжийн дагуу төвийн 2, орон нутаг дахь 7 нэгжийн албан хаагчид 215 улсын 151170 гадаадын иргэний хугацаа хэтрүүлсэн мэдээлэлд бүртгэлээр хяналт тавихад Монгол Улсын хилээр гарсан 107727, хилээр гараагүй 41542, оршин суух зөвшөөрөлтэй 1728, нас барсан 173 иргэн байсныг олж тогтоон, Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.	танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Жилийн эцэст: Илрүүлсэн зөрчлийг цэгцлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг шинээр үүсгэх виз, бүртгэл, хяналтын нэгдсэн санд хуулбарлан оруулах, энэ талаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан байна	Хууль зүй, дотоод хэргийн сайдад биечлэн танилцуулсан. ISM системд мэдээлэл засварлах маягтын дагуу 22 удаагийн засвар үйлчилгээ хийж, давхардсан тоогоор 61 хэрэглэгчийн эрхийг шилжүүлэн сервер гэмтсэн гацсан үед ашиглах аваарын программ хангамжийг хөгжүүлэн 08 дугаар сарын 22-ны өдрөөс нэвтрүүллээ.	
Хэсгийн дундаж хувь: 91.1							
Зорилт 2. Гадаадын иргэн, харьяатын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр зорилт)							
10	Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй болгох, зөрчил, давхардал, хийдлийг арилгах	Урсгал зардлаар	Боловсруулж батлуулсан болон санал өгсөн хууль тогтоомжийн тоо.	Байгууллагын даргын 2021 оны А/147 дугаар тушаалаар байгууллагын даргын тушаалаар баталсан байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан тушаал, шийдвэрт холбогдох өөрчлөлтийг тусгах, шинэчлэн батлуулах ажлын хэсэг байгуулагдаж шинэчлэн боловсруулах шаардлагатай хэм	Эхний хагас жил, жилийн эцэст: Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй болгох, зөрчил, давхардал, хийдлийг арилгах зорилгоор журмын төсөл,	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-д орсон нэмэлт, өөрчлөлт, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн 8 хуулийн төсөл, Засгийн газрын тогтоолоор батлах 3 журмын төсөл, 2 тогтоолын төсөл, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар батлах 6 журмын төсөлд	100

1	2	3	4	5	6	7	8
				<p>хэмжээ тогтоосон эрх зүйн актын жагсаалт гаргаж, байгууллагын даргын тушаалаар баталсан 4 журмыг шинэчлэн боловсруулсан.</p>	<p>нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж нэгжүүдээс санал авч, хэлэлцүүлэн батлуулсан байна.</p>	<p>саналаа тусган холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлээ. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд саналыг 01/369 дүгээр, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд саналыг 01/661 дүгээр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд саналыг 01/723 дугаар, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд саналыг цахимаар, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг 01/1351 дүгээр, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг 01/1831 дүгээр, Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд саналыг 01/2011 дүгээр, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг 01/2061 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын тогтоолоор батлах “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох түр журам”-ын төсөлд саналыг 01/133 дугаар, “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах тухай” төсөлд саналыг 01/2055</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.</p> <p>Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлах “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын төсөлд саналыг 01/918 01/919 дүгээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлах “Гадаадын иргэнд хүүхэд үрчлэх журам”-ын төсөлд саналыг 01/772 дугаар, “Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журам “-ын төсөлд саналыг 01/1973 дугаар, “Чөлөөт бүсэд мөрдөх журам”, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам-ын төсөлд тус тус саналыг 01/2054 дүгээр албан бичгээр холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлжээ.</p> <p>“Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын төслийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/08</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>дугаар тушаалаар батлууллаа. Үүнтэй холбогдуулан байгууллагын даргын 2016 оны А/241 дүгээр тушаалаар баталсан “Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ыг байгууллагын даргын 2022 оны А/27 дугаар тушаалаар хүчингүй болгож шийдвэрлүүлэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Тайлант онд байгууллагын даргын тушаалаар үйл ажиллагааг зохицуулсан 11 дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлав.</p>	
11	Иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэдэг олон улсын хууль, тогтоомж, хэрэглээний талаар харьцуулсан судалгаа хийх	Урсгал зардал	- Судалгаа, шинжилгээг удирдлагад танилцуулсан огноо.	-	Жилийн эцэст: Иргэний харьяаллын талаарх улс орнуудын харьяатын хууль тогтоомжуудыг удирдлагад танилцуулсан байна.	<p>1994 оноос хойш Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон иргэдийн дэлгэрэнгүй судалгааг 09 дүгээр сарын 29-ний өдөр, Иргэний харьяаллын Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдлын болон Монгол Улсын иргэний харьяаллын талаарх эрх зүйн зохицуулалтыг Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа хийж, судалгааны дүгнэлт, тоон мэдээг 10 дугаар сарын 04-ний өдөр тус тус танилцууллаа.</p> <p>“Дэлхийн улс орнуудын давхар харьяаллын талаарх баримталж буй бодлого” сэдэвт харьцуулсан судалгаа хийж, тайланг 11 дүгээр сарын 29-ний</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн.	
Хэсгийн дундаж хувь: 100							
Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ. /ХЗДХС-ын ЭАХ-ний 2021-2024 ҮАСТ-ний 7.4/							
12	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн зөрчлийг шийдвэрлэж, зохих ангиллын оршин суух зөвшөөрлийг олгон, бүртгэх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Хоёрдмол харьяалалтай иргэдийн асуудлыг шийдвэрлэхээр зохион байгуулсан арга хэмжээ, танилцуулга, илтгэх хуудасны тоо, дугаар, огноо; - Шийдвэрлэлтийн тайлан. 	Иргэний харьяаллын газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэстэй хамтран мэдээллийн санд бүртгэлтэй хоёрдмол харьяалал үүсгэсэн 744 (Бүгд Найрамдах Казахстан улсын) иргэний мэдээллийг шүүж, 2021 оны 01/05-15 дугаартай удирдамж батлуулан Улаанбаатар хот, Дархан-Уул, Ховд, Баян-Өлгий аймагт оршин сууж буй Монгол Улсын харьяатаас гаралгүйгээр Казакстан улсын харьяат болсон 122 иргэнийг илрүүлж, үүнээс 87 иргэний асуудлыг шийдвэрлэсэн.	Эхний хагас жилд: Хоёрдмол харьяалал үүсгэсэн БНКаЗУ-ын иргэдийг бүртгэлжүүлсэн байна. Жилийн эцэст: Хоёрдмол харьяалалтай иргэдийн тоо буурч, хоёрдмол харьяаллын зөрчил шийдвэрлэгдсэн байна.	Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 547 иргэнийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д шинээр бүртгэсэн бол Бүгд Найрамдах Казахстан Улсын ЭСЯ-ны ноот бичгийг үндэслэн 23 иргэнийг тус санд хоёрдмол харьяалал үүсгэсэн бүртгэлээс хасалт хийв. Хоёрдмол харьяалал үүсгэсэн Бүгд Найрамдах Казахстан Улсын 818 иргэний мэдээлэл, хилээр нэвтэрсэн байдал, хаягийн тодорхойлолтыг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-аас шүүж, мэдээллийг 05 дугаар сарын 24-ний өдөр Баян-Өлгий аймаг дахь хэлтэст хүргүүлсэн. Байгууллагын даргын 05 дугаар сарын 12-ны өдрийн Б/135 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах, зөрчил дутагдлыг арилгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх газрын албан	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>хаагчдыг тус хэлтэст сэлгэн ажиллуулж эхэллээ. Тус байгууллагын Баруун бүс дэх газар “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д Бүгд Найрамдах Казахстан Улсын хоёрдмол харьяалал үүсгэсэн 910 иргэний мэдээллээс Ховд аймгийн регистрийн дугаартай 192 иргэний мэдээлэлд шүүлт хийж, Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн 7997 иргэний нэрстэй тулгаж ажиллав.</p>	

1	2	3	4	5	6	7	8
13	Хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д үйл ажиллагаа явуулах	Урсгал зардал	Хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний тоо.	Коронавируст цар тахлын нөхцөл байдлын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д гадаадын иргэний хяналтын улсын байцаагч томилон ажиллуулаа, 2021 оны 11 дүгээр сараас эхлэн виз, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж эхэлсэн.	Эхний хагас жил, жилийн эцэст: Хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д хяналтын улсын байцаагч, виз бүртгэлийн мэргэжилтэн томилж ажиллуулсан байна.	Тайлант хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д виз, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж, биечлэн 2002 иргэнд, утсаар 2686 иргэнд зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлжээ. Харин коронавируст цар тахлын нөхцөл байдлын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосон, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.14 дэх хэсэгт “Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй, оршин суух зөвшөөрөл аваагүй, визийн болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй бол тус нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд бүртгэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлнө” гэж заасан тул “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д гадаадын иргэний хяналтын улсын байцаагч томилон ажиллуулаагүй.	100
14	Гадаадын иргэнд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл, хувийн хэргээр зорчих урилга, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох, сунгах, хасах,	-	- Үйлчилгээ үзүүлсэн тоо; Цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо.	-Визийн зөвшөөрөл 10924; -Визийн шилжүүлэг 19; -Монгол Улсын виз 3372; -Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олголт 5938; - Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалт	Эхний хагас жилд: Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай, алдаа дутагдалгүй хүргэж, тоон үзүүлэлт гарсан байна.	Тайлант онд 17385 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл, түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн хилийн боомтод үндэслэн 4451 иргэнд хилийн боомтод, төв байгууллагад 14 иргэнд буюу нийт 4465 гадаадын	100

1	2	3	4	5	6	7	8
	визийн ангилал өөрчлөх, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийх				Сүүлийн хагас жилд: Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай хүргэж, тоон үзүүлэлт гарсан байна.	<p>иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон.</p> <p>Мөн 83 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олгож, 16 иргэний визийн шилжүүлэг хийлээ.</p> <p>Тайлант онд нийт 6206 аж ахуйн нэгж, байгууллагын 19051 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.</p> <p>Визийн мэдээллийн нэгдсэн сан "evisa.mn" системээр нийт 36 улсын 7551 иргэнд цахим виз олгож, 16 улсын 144 гадаадын иргэний визийн хүсэлтэд татгалзсан.</p> <p>Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 9236 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 15133 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 7111 иргэний бүртгэлд хасалт хийв.</p> <p>Гадаадын иргэнийг уригч 374 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 945 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 8206 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 5446 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгажээ.</p> <p>"Монгол Улсад оршин суух үнэмлэх" 15975 ширхэг шинээр хэвлэж, 8377 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган,</p>	

1	2	3	4	5	6	7	8
						375 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Оршин суух зөвшөөрөл сунгуулах хүсэлт ирүүлсэн 1254 гадаадын иргэний хүсэлтийг байгууллагын даргын 27 удаагийн тушаалаар шийдвэрлэж, 70 иргэнд регистрийн дугаар, 1 иргэнд зорчих үнэмлэх олгосон.	
15	Иргэдэд үйлчилгээний талаарх зөвлөгөө, мэдээллийг тусгай дугаарын лавлах утсаар болон зөвлөгөө, мэдээллийн төвөөр дамжуулан үнэн зөв, шуурхай хүргэх	-	- Зөвлөгөө өгсөн иргэдийн тоо.	1800-1882 дугаарын утсаар 15577, биечлэн 1273, автомат хариулагчаар 2530, байгууллагын цахим шуудангаар 204, байгууллагын нүүр ном буюу “фэйсбоок” хуудасны чатботоор 2530 нийт 22114 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Иргэдэд зөвлөгөө, мэдээллийг хуулийн дагуу үнэн зөв хүргэсэн байна.	Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 39883 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үүнээс: - 1800-1882 дугаарын утсаар-34260, - Биечлэн-4145, - Имэйлээр-1469 иргэнд	100
16	Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр холбогдох ажиллагааг хийх	-	- Үзүүлсэн үйлчилгээний тоо; - Ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэрийн дугаар.	Ерөнхийлөгчийн 11 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон 11, Ерөнхийлөгчийн 14 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 212 иргэний мэдээллийг тус тус холбогдох газруудад хүргүүлж, мэдээллийн санд баяжилт хийсэн. Ерөнхийлөгчийн 3 удаагийн зарлигаар 21 иргэн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон.	Эхний хагас жил, жилийн эцэст: Иргэний харьяалалтай холбоотой хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр ЗГХЭГ, ЕТГ-т хүргүүлэх, шийдвэр гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудад мэдээллийг шуурхай хүргэн, бүртгэл,	Харьяатын асуудлаар нийт 167 иргэн, 14 харьяалалгүй хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, 156 иргэн, 19 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа. Түүнчлэн 140 иргэн, 19 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 139 иргэн, 18 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 02 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар,	100

1	2	3	4	5	6	7	8
					мэдээллийн сан хөтөлсөн байна.	<p>10 дугаар сарын 31-ний өдрийн 206 дугаар зарлигаар тус тус Оросын Холбооны Улсын 2 иргэн Монгол Улсын харьяат болсон.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 207 дугаар зарлигаар харьяалалгүй 1 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгож, гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, мэдээллийн санд баяжилт хийсэн.</p> <p>Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 9, Оросын Холбооны Улсын 2 буюу нийт 11 гадаадын иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр ирүүлснийг хүлээн авав.</p> <p>Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 6, Оросын Холбооны Улсын 1, Румын Улсын 1 буюу нийт 8 гадаадын иргэний хүсэлтийг түдгэлзүүллээ.</p> <p>Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт ирүүлсэн 156 иргэн, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 14 хүний хүсэлт, баримт бичгийг шинээр ирүүлснийг хүлээн авсан.</p> <p>1994-2022 онд Монгол Улсын харьяат болсон 131 иргэний мэдээллийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д шинээр бүртгэсэн.</p>	
17	Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний	-	- Үрчлэлтийн дараах тайланд	Байгууллагын “Мэргэжлийн зөвлөлийн хурал”-аар Монгол Улсын харьяат 1	Эхний хагас жилд: Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх	Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлтэй 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ярилцлага	100

1	2	3	4	5	6	7	8
	хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналтыг тавих		<p>хяналт тавьсан тоо;</p> <ul style="list-style-type: none"> - Хийсэн гурван талт гэрээний огноо; - Хяналт тавих гэрээний тоо. 	<p>хүүхдийг Америкийн Нэгдсэн Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлэх шийдвэр гарч, 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр үрчлэлтийн дараа хяналт тавих 2 талт гэрээг байгуулсан. Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан (Солонгос Улсын 1, Итали Улсын 1) нийт 2 гэр бүлийн хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.</p>	<p>хүсэлтийн дагуу холбогдох ажиллагааг хийж, үрчлэлтийн дараах тайланд хяналт тавин бүртгэл судалгааг хөтөлсөн байна. Жилийн эцэст: Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлтийн дагуу холбогдох ажиллагааг хийж, үрчлэлтийн дараах тайланд хяналт тавин бүртгэл судалгааг хөтөлсөн байна.</p>	<p>зохион байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр байгууллагын "Мэргэжлийн зөвлөлийн хурал"-аар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Байгууллагын даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар Монгол Улсын харьяат 1 хүүхдийг Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлд үрчлүүлж, 01 дүгээр сарын 06-ны өдөр үрчлэлтийн дараа хяналт тавих 3 талт гэрээг байгуулав. Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Итали Улсын 1 иргэн, гэр бүлийн хүсэлт, баримт бичгийг 11 дүгээр сарын 23-ны өдөр шинээр хүлээн авсан. Гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн нийт 18 хүүхдийн тайланг хүлээн авч, "Гадаад улсын иргэнд үрчлүүлсэн Монгол Улсын харьяат хүүхдийн мэдээллийн сан"-д бүртгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Америкийн Нэгдсэн Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн 7; - Бүгд Найрамдах Итали Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн 4; - Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн 7 хүүхэд. 	
18	Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах	-	<ul style="list-style-type: none"> - Холбогдох журмын дагуу хугацаанд нь үйлчилгээ үзүүлэх; - Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон, 	<p>Байгууллагын 4 удаагийн Мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хүсэлт гаргасан 62 /давхардсан тоогоор/ олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын</p>	<p>Эхний хагас жил, жилийн эцэст: "Мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагын даргын тушаал гарч, бүртгэл, мэдээлэл хөтлөн</p>	<p>Байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалаар "Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлав.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
	зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох		сунгасан, зөвшөөрлийг хүчингүй болгосон тоо.	хүсэлтийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. - Шинээр нээх-3 - Сунгалт-49 - Хүчингүй болгох-9	ажилласан байна.	Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой 28 байгууллагын санал (зөвшөөрлийн хугацааг сунгуулах 28)-ыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Байгууллагын "Мэргэжлийн зөвлөл"-ийн 6 удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн нийт 41 газрын асуудлыг хэлэлцүүлэн, 3 байгууллагад үйл ажиллагааны зөвшөөрөл олгож, 33 байгууллагын хугацааг сунгаж, 5 байгууллагын зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэлээ. Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа 59 олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн авч, 9 байгууллагад тодорхойлолт олгов.	
19	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв /8.5 сая төгрөг/	- Албадан гаргасан гадаадын иргэдийн тоо; - Тушаалын огноо.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.4, 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 14 улсын 31 иргэнийг 29 удаагийн тушаалаар албадан гаргасан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Хяналтын улсын байцаагчийн холбогдох хууль тогтоомжид нийцсэн дүгнэлтийг үндэслэн байгууллагын даргын тушаал гарсан байна.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.4, 37.1.6, 37.1.7, 37.1.8, 37.1.9, 37.1.10, 37.1.11, 37.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн 15 улсын 63 гадаадын иргэнийг байгууллагын даргын 2022 оны А/04, А/08, А/09, А/10, А/30, А/37, А/41, А/49, А/55, А/56, А/57, А/58, А/65, А/76, А/77, А/78, А/100, А/105, А/106, А/107, А/115, А/116, А/121, А/128, А/129, А/130, А/138, А/143, А/152, А/162, А/164, А/165, А/183, А/185, А/190, А/193, А/198, А/204, А/206, А/209, А/216, А/200,	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>A/221 дугаар бүхий нийт 43 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргахаар шийдвэрлэж, паспорт болон паспортыг орлох баримт бичигт холбогдох тэмдэглэгээг үйлдэн, мөн хуулийн 40¹ дүгээр зүйлд заасан “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISM программ) болон “Визийн мэдээллийн нэгдсэн сан” (evisa.mn программ)-д тухай бүр бүртгэж, Гадаад харилцааны яам, Хил хамгаалах ерөнхий газартай харилцан мэдээлэл солилцон хяналт тавин ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн 8; - мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан 1; - хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн 5; - эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн 7; - ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан 6; - сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй 1; - нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж хуульд заасны дагуу хариуцлага хүлээсэн гадаадын иргэний талаар 	

1	2	3	4	5	6	7	8
						<p>цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн 2;</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн 3; - шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн, ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн 22; - түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн 8 гадаадын иргэнд хориг арга хэмжээг авч, тус тус Монгол Улсаас албадан гаргахаар шийдвэрлэв. 	
20	Хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, шийдвэрлэх	-	- Хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн болон хил нэвтрэхэд хяналт тавьсан гадаадын иргэний тоо.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 7 улсын 28 иргэнийг 27 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн.	Эхний хагас жил, жилийн эцэст: Хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу гадаадын иргэний хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн байгууллагын даргын тушаал гарч, хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг Монгол Улсын хил нэвтрэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьсан байна.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь заалтыг үндэслэн 6 улсын 49 иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг байгууллагын даргын 41 удаагийн тушаалаар түдгэлзүүлж, мөн 22 удаагийн тушаалаар 7 улсын 27 иргэний гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн.	100
21	Гадаадын иргэнийг хуульд заасан	-	Саатуулсан болон сулласан	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд	Эхний хагас жилд: Хяналтын улсын	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2, 36.1.3 дахь заалтыг үндэслэн	100

1	2	3	4	5	6	7	8
	үндэслэлээр шүүгчийн захирамжаар саатуулах ажиллагааг зохион байгуулах		гадаадын иргэний тоо.	заасан үндэслэлээр Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 6 удаагийн захирамжаар Америкийн Нэгдсэн Улсын 1, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4 иргэнийг саатуулж, Америкийн Нэгдсэн Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4 иргэний саатуулсан хугацааг 30 хоногоор сунгаж, сулласан байна.	байцаагчийн саналыг үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрийн биелэлтийг ханган ажилласан байна. Жилийн эцэст: Хяналтын улсын байцаагчийн саналыг үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрийн биелэлтийг ханган ажилласан байна.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 9 удаагийн захирамжаар Америкийн Нэгдсэн Улс болон Швейцар Улсын хоёрдмол харьяалалтай 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын 1, Оросын Холбооны Улсын 1 иргэнийг саатуулж, уг иргэдээс 6 иргэний саатуулсан хугацааг 6 удаагийн захирамжаар 30 хоногоор тус бүр 1 удаа сунгаж, 9 иргэнийг сулласан байна.	
22	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	-	- Хяналт шалгалт явуулсан тоо, илэрсэн зөрчлийн тоо, хүргүүлсэн шаардлагын тоо, түүний шийдвэрлэлт.	2021 онд төлөвлөгөөт 35, төлөвлөгөөт бус 199 (удирдамжийн дагуу 21, өргөдөл гомдлын дагуу 40, гомдол мэдээллийн дагуу 138), нийт 234 удаагийн хяналт шалгалтаар 436 аж ахуйн нэгж байгууллага 2016 гадаадын иргэний баримт бичгийг шалгасан байна.	Эхний хагас жил, жилийн эцэст: Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд төлөвлөгөөт 13 удаагийн хяналт шалгалтаар 94 байгууллагын 370 гадаадын иргэний баримт бичигт шалгалт хийж, 2 зөрчлийг илрүүлэн албан шаардлага хүргүүлсэн. Байгууллагын даргын 209 удирдамж, орон нутаг дахь нэгжийн даргын 21 удирдамж болон 68 өргөдөл гомдол, 24 гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус 322 удаагийн хяналт шалгалтыг 480 аж ахуйн нэгж, байгууллага, 1746 гадаадын иргэнийг хамруулан зохион байгуулж, 138 зөрчлийг илрүүлэн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.	100

1	2	3	4	5	6	7	8
						Дээрх хяналт шалгалтын хүрээнд гэмт хэргийн шинжтэй 3 үйлдлийг илрүүлэн, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанд тус тус шилжүүллээ.	
23	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэн, уригчийн зөрчлийг шийдвэрлэх	-	- Зөрчил гаргасан гадаадын иргэн, уригч байгууллага, уригч иргэний тоо, оногдуулсан мөнгөн дүн.	95 гадаадын иргэн, 8 уригч байгууллага (12 иргэн)-д Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 33 сая 780 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Зөрчлийг хуулийн хугацаанд шалгаж, түргэн шуурхай шийдвэрлэсэн байна.	2022 онд нийт 286 гадаадын иргэн, 6 уригч байгууллага (6 иргэн), 1 уригч иргэн (1 иргэн)-д Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 83,590,000 төгрөг (Наян гурван сая таван зуун ерэн мянган)-ийн торгох шийтгэл ногдууллаа.	100
Хэсгийн дундаж хувь: 100							
Стратеги зорилго 2. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, салбарын санхүүгийн чадавх, менежментийг сайжруулна. (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 7.5)							
Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах							
24	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	Урсгал зардлаар	- Батлагдсан төлөвлөгөө; - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	2021 оны төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 5 бүлэг, 8 зүйлтэй, 4 үндсэн зорилтын хүрээнд 41 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, байгууллагын даргын 2021 оны А/62 дугаар тушаалаар баталж, хэрэгжилт 95.8 хувьтай байна.	Эхний хагас жилд: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөг батлуулах Жилийн эцэст: Төлөвлөгөөний хэрэгжилт 90-100 хувьтай хангагдсан байна.	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөг "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн 2, 3, 4 дүгээр зорилтын хүрээнд 47 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталлаа. Албан хаагчдад зэрэг дэв олгуулах хүсэлтийг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/346 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 01/345 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж, дэс түшмэлийн тэргүүн 7, дэд 24, гутгаар 17, дөтгөөр 5, нийт 53 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан батлуулав. Байгууллагын даргын 2022 оны Б/70 дугаар тушаалаар нийт 67 албан хаагчийн цалингийн шатлалыг	100

1	2	3	4	5	6	7	8
						шинэчлэн тогтоож, "А буюу маш сайн" үнэлэгдсэн 7 албан хаагчийн шатлалыг алгасуулж, "В буюу сайн" үнэлэгдсэн 60 албан хаагчийн шатлалыг ахиуллаа. "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө"-ний хүрээнд мэргэшил дээшлүүлэх, суралцах боломжийг хангах зорилгоор байгууллагын даргын 19 удаагийн тушаалаар 15 албан хаагчид цалинтай, 4 албан хаагчид цалингүй чөлөө олгож, хяналтын улсын байцаагчийн хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны урамшуулалд хамрагдах эрх үүссэн 17 албан хаагчийн мөнгөн урамшууллыг олгосон.	
25	Албан хаагчдыг сургах 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангах	Урсгал зардлаар	- Батлагдсан төлөвлөгөө; - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	Байгууллагын 2021 оны сургалтын төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 21-ны өдөр 7 зорилтын хүрээнд 24 арга хэмжээтэй баталж, мөн Төрийн албаны зөвлөлийн 2020 оны "Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай" зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталж, төлөвлөгөөний хэрэгжилт 95,8 хувийн хэрэгжилттэй ажиллав.	Жилийн эцэст: Төлөвлөгөөний хэрэгжилт 90-100 хувьтай хангагдсан байна.	"Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын 2022 оны төлөвлөгөө"-г 01 дүгээр сарын 28-ны өдөр батлан, төлөвлөгөөний хүрээнд 45 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2521 албан хаагчийг хамруулсан. Бүгд Найрамдах Энэтхэг Улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 албан хаагчийг, төрийн болон бусад байгууллагатай хамтран төрийн албан хаагчийн "Мэргэшүүлэх багц сургалт" болон "Алсын хараа 2050", "Цахим хөгжлийн багц хууль", "Кибер аюулгүй байдал", "Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал" зэрэг 36 удаагийн сургалтад давхардсан тоогоор 289 албан хаагчийг тус тус суралцууллаа.	100
26	Сул орон тооны сонгон шалгаруулалтыг	Урсгал зардлаар	- Нөхөгдсөн сул орон тоо.	4 удаагийн сонгон шалгаруулалтаар удирдах 2, гүйцэтгэх 29,	Эхний хагас жил, жилийн эцэст:	Томилгооны зөрчлийг арилгах зорилгоор сул орон тооны сонгон шалгаруулалтыг нийт 6 удаа зохион	100

1	2	3	4	5	6	7	8
	зохион байгуулж, сул орон тоог нөхөх			албан тушаалын сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулсан. Тэнцсэн иргэдээс 11 нь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэдийн нөөцөд бүртгэлтэй, 17 нь 2018-2021 оны төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэд байна.	Сул орон тоо нөхөгдсөн байна.	байгуулж, 20 албан тушаалын сул орон тоог нөхсөн байна. Мөн 5 удаагийн сонгон шалгаруулалтаар удирдах 4, гүйцэтгэх 8 албан тушаалын сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгууллаа.	
27	Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжүүлэн ажиллах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төлөвлөгөөний тоо, огноо; - Төлөвлөгөөний хэрэгжилт гаргасан огноо, хэрэгжилтийн хувь. 	Дээд газрын тогтоол, шийдвэрээр батлагдсан 6 үндэсний хөтөлбөрийг бүртгэл, хяналтад авч ажиллан, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор байгууллагын даргын 2021 оны А/200 дугаар тушаалаар “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” батлуулсан.	Эхний хагас жилд: Нийт 6 төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьсан байна. Жилийн эцэст: Хэрэгжилтийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний хүрээнд “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө”-г байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар 03 дугаар сарын 15-ны өдөр баталж, биелэлтийг 12 дугаар сарын 08-ны өдөр тооцлоо. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 01 дүгээр сарын 24-ний өдөр, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр тус тус тусгайлан баталсан. Түүнчлэн “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хагас жилийн тайланг 06 дугаар сарын 30-ны өдрийн 03/1219 дүгээр, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хагас жилийн тайланг 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/1262	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>дугаар, “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2012-2022 оны тайланг 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1703 дугаар, “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2018-2022 оны төлөвлөгөөний хүний эрх, жендерийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт болон 2023-2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тусгах саналыг 11 дүгээр сарын 09-ний өдрийн 02/1954 дүгээр, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн тайланг 10 дугаар сарын 07-ны өдрийн 02/, 1848 дугаар, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайланг 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/2150 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэв.</p>	
28	<p>Байгууллагын хэмжээнд “Дэлхийд ганц босоо зурлагатай монгол бичгээ хамтдаа сурцгаая” аяныг хэрэгжүүлэх</p>	1,0 сая	<ul style="list-style-type: none"> - Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний батлагдсан огноо; - Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо; - Монгол бичиг нэвтрүүлсэн үйл 	<p>Байгууллагын гаднах хаяг (<i>төв, Зүүн бүс дэх газар, Баруун бүс дэх газар болон Дорноговь аймаг дахь газар</i>), туг, байгууллагад ашиглаж буй 1 тамга, 1 тэмдэг, боомт, орон нутаг дахь нэгжийн нийт 7 тэмдэг, ялгах тэмдэг (<i>жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг</i>)-т үндэсний бичгийг оролцуулсан бичиглэлтэй. Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн</p>	<p>Эхний хагас жил: “Дэлхийд ганц босоо зурлагатай монгол бичгээ сурцгаая” аяныг санаачлан, удирдамж төлөвлөгөө батлуулсан байна. Жилийн эцэст: Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэгжилтийг гаргаж, удирдлагад</p>	<p>“Дэлхийд ганц босоо зурлагатай монгол бичгээ хамтдаа сурцгаая” аяны хүрээнд Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр баталж, биелэлтийг 11 дүгээр сарын 21-ний өдөр тооцон тайлан гаргалаа. Үйл ажиллагааны хүрээнд байгууллагын 2022 оны цаг тооны хуанли дахь бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичиж, хэвлүүлсэн. “Монгол бичиг”-ийн сорилд 51 албан хаагчийг хамруулан мэдлэгийн түвшингээр эрэмбэлж, “Дархан энх</p>	100

1	2	3	4	5	6	7	8
			ажиллагааны тоо.	үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа"-нд http://mongol-bichig.1212.mn/ цахим хаягаар байгууллагын албан хаагчид хамрагдаж, судалгааг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.	танилцуулсан байна.	<p>оршихуй” сургалтын төвтэй хамтран 04 дүгээр сард “Монгол бичиг”-ийн анхан, дунд шатны танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 36 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Агаарын замын боомт хариуцсан газар 04, 05 дугаар сард, Баруун бүс дэх газар 05 дугаар сард “Монгол бичгийн хичээл”-ийг тус бүр зохион байгуулсан бол Зүүн бүс дэх газар 01 дүгээр сараас эхлэн албан хаагчдыг 7 хоног тутам, Дорноговь аймаг дахь газар 04, 05 дугаар сард 3 дахь жилдээ зохион байгуулж албан хаагчдаа хамруулжээ. Монгол-Шведийн хамтарсан эх хэл соёлыг хөгжүүлэх төвтэй хамтран 09 дүгээр сараас эхлэн Баян-Өлгий аймаг дахь хэлтэс албан хаагчдаа үндэсний бичгийн сургалтад суралцуулж эхлэв. “Монгол бичиг-III” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Үндэсний бичиг, үсгийн баяр”-ыг тохиолдуулан Дорноговь аймаг дахь газрын 19 албан хаагч “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийг Монгол бичигт хөрвүүлснийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтэд сурталчиллаа.</p> <p>Байгууллагын төв болон орон нутаг дахь нэгжүүд албан өрөөнүүдийн хаягийг Үндэсний бичигт хөрвүүлэн шинэчилж, Баруун бүс дэх газар нийт компьютерт, Зүүн бүс дэх газар архив-бичиг хэргийн эрхлэгчийн ажлын компьютерт монгол бичгийн үсгийн программ суулгав.</p> <p>Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь үндэсний</p>	

1	2	3	4	5	6	7	8
						бичгийн сургалтыг 11 дүгээр сард танхимаар зохион байгуулж, Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Үндэсний бичигтэн 2022-2024 хөдөлгөөн”-ий нээлтийн арга хэмжээнд тус газраас 5 албан хаагч оролцлоо.	
29	Удирдах албан тушаалтан, албан хаагчдын нэгдсэн цугларалт, зөвлөгөөн зохион байгуулах	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын төслийн санхүүжилтээр	- Зөвлөгөөн болсон огноо, хамрагдсан албан хаагчдын тоо, үр дүн.	Байгууллагын даргын 12 дугаар сарын 10-ны өдрийн 01-03/32 дугаартай удирдамжийн дагуу “Удирдах албан тушаалтны цугларалт”-ыг 12 дугаар сарын 23,24-ний өдрүүдэд байгууллагын төвд зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны ололт, дутагдлыг дүгнэж, цаашид хэрхэн ажиллах талаар хэлэлцэж, удирдах албан тушаалтны сургалтыг Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн үндэсний байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Төрийн албаны хөгжлийн хөтөлбөрийн төсөл”-ийн багтай хамтран зохион байгуулав.	Жилийн эцэст: Цугларалтыг удирдах албан тушаалтан болон хяналтын улсын байцаагч, захиргааны ахлах мэргэжилтнүүдэд тус тус зохион байгуулж, арга зүйн удирдлагаар ханган туршлага солилцож, ажлын арга барил сайжирсан байна.	Удирдах албан тушаалтан, албан хаагчдын нэгдсэн цугларалт, зөвлөгөөн, тайлангийн хурлыг 12 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулж, 2022 оны үйл ажиллагааны үр дүн, 2023 оны төлөвлөгөөг хэлэлцлээ.	100
30	Албан хэрэг хөтлөлт, тайлан, төлөвлөлтийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах	Урсгал зардал	- Зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагаанд захиргааны үйл ажиллагаа, албан хэрэг	2021 онд Баруун бүс, Хойд бүс, Агаарын замын боомт хариуцсан газрын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, үр дүнг удирдлагад илтгэх хуудсаар танилцуулан,	Эхний хагас жилд: Орон нутгийн 3 зохион байгуулалтын нэгжийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт	Байгууллагын даргын 2021 оны “Баруун бүс дэх газрын үйл ажиллагааны зөрчил дутагдлыг арилгуулах тухай” 15 дугаар албан даалгаврын биелэлтийг шалгах гүйцэтгэлийн болон Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2020, 2021, 2022 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаа,	100

1	2	3	4	5	6	7	8
			хөтлөлтийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалтын тоо, удирдамж, илтгэх хуудасны огноо, дугаар; Зохион байгуулсан сургалт, зөвлөмжийн тоо, огноо.	нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэн ажилласан.	хийж, ажил сайжруулах зөвлөмж хүргүүлэн, 1 удаа сургалт зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Төвийн зохион байгуулалтын 4 нэгжийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, ажил сайжруулах зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.	санхүүгийн чиглэлээр дотоод хяналт шалгалтыг байгууллагын даргын 01-03/20 дугаар удирдамжийн дагуу 04 дүгээр сарын 14-өөс 18-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Байгууллагын даргын 10/03 дугаар удирдамжаар Дорноговь аймаг дахь газрын хууль, эрх зүйн хүрээнд гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-10/08 дугаар илтгэх хуудсаар тайлагнан зөвлөмжийг тус нэгжид хүргүүллээ. Байгууллагын даргын баталсан 10 дугаар сарын 11-ний өдрийн 01-02/52 дугаар удирдамжийн дагуу төвийн зохион байгуулалтын нэгж болох Виз, зөвшөөрлийн газар, Иргэний харьяаллын газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн 2022 оны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 10 дугаар сарын 14-өөс 31-ний өдрүүдэд хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүн, саналыг 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01-02/79 дүгээр илтгэх хуудсаар тайлагнан шалгалтын мөрөөр 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Албан хэрэг хөтлөлтийг сайжруулах тухай" 03 дугаар зөвлөмжийг боловсруулан холбогдох нэгжүүдэд хүргүүлэв.	
31	Төрийн болон албаны нууцын биет хамгаалалтыг сайжруулах	Урсгал зардал	- Худалдан авсан сейфний тоо, огноо.	Байгууллагын даргын 2020 оны А/87 дугаар тушаалаар төрийн 1, 2 дугаар түвшний нууцтай танилцах эрх бүхий 34	Эхний хагас жилд: Худалдан авалтыг зохион байгуулж, сейфийг	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар болон "Голден-Хоул" ХХК-ны 2022 оны 06 сарын 07-ны өдөр байгуулсан ХО-Б/03/2022 тоот гэрээний хэрэгжилтийн	100

1	2	3	4	5	6	7	8
	/Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 10 дугаар зүйл 10.12 хэсэг/			албан тушаалыг баталсан ба одоогоор 13 нь зориулалтын сейфтэй.	хуваарилан байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна.	дагуу нэг бүрийн 3,250,000 төгрөгийн үнэ бүхий 25 ширхэг буюу нийт 81,250,000 төгрөгийн хүндрүүлэгчтэй сейфийг 10 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, төрийн нууцтай танилцах эрхийн 1, 2 дугаар түвшний эд хариуцагч 20 албан хаагчид хүлээлгэж өгөн, 5 сейфийг нөөцөд үлдээлээ.	
32	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж албан даалгавар боловсруулах	Урсгал зардлаар	- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, боловсруулсан арга хэмжээний санал, зөвлөмж албан даалгаврын тоо.	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулан ажилласан.	Эхний хагас жил, Жилийн эцэст: Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан байна.	“Дотоод, хяналт шалгалтын 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-г 02 дугаар сарын 21-ний өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 33, гүйцэтгэлийн 1 нийт 35 дотоод хяналт шалгалтыг 36 албан хаагчид холбогдуулан зохион байгуулж, 1 баримт материалыг Авлигатай тэмцэх газарт, 2 баримт материалыг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Байгууллагын даргын тушаалаар өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах болон нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэлийг 13 албан хаагчид, албан тушаалын цалинг 3 сар хүртэл 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг 7 албан хаагчид, төрийн албанаас халах сахилгын шийтгэлийг 3 албан хаагчид ногдуулж, 4 албан хаагчийн “Ёс зүйн хариуцлагын талон”-ыг цоолсон анхааруулга өгч, 1 албан хаагчийг өөрийн хүсэлтээр нь төрийн албанаас чөлөөлөв.	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>Сахилгын зөрчил гаргасан болон ажлын хариуцлага алдсан нь тогтоогдоогүй зэрэг үндэслэлээр 6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулаагүй.</p> <p>“Баруун бүс дэх газрын үйл ажиллагааны зөрчил дутагдлыг арилгуулах тухай” 2021 оны 15 дугаар албан даалгаврын биелэлтийг шалгах гүйцэтгэлийн, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2020, 2021 оны үйл ажиллагаа, 2022 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд дотоод аудитыг зохион байгуулж санал, дүгнэлт гаргасан.</p>	
33	<p>Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, удирдлагын бодлого шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах</p>	Урсгал зардлаар	<p>- Бэлтгэсэн мэдээний тоо; Мэдээ, ярилцлага нийтлэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо.</p>	<p>Цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 109 мэдээ байршуулж, давхардсан тоогоор 441 хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Үүнд: телевизээр 66, сонинд 40, сайтад 351 мэдээлэл нийтэлснээс 2 сонины ярилцлага, 6 видео (нэвтрүүлэг, шторк) бэлтгэн нийтлүүлсэн байна.</p>	<p>Эхний хагас жилд: Бэлтгэсэн мэдээ, ярилцлагыг давхардсан тоогоор 50-аас доошгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. Жилийн эцэст: Бэлтгэсэн мэдээ, ярилцлагыг давхардсан тоогоор 50-аас доошгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой 116 мэдээ, 3 ярилцлага, 7 видео, бусад төрлийн 3 мэдээлэл байршуулж, давхардсан тоогоор 485 хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Үүнээс телевизээр 55, сонинд 35, сайтад 395 мэдээлэл нийтлүүлсэн байна.</p> <p>Тухайлбал, визийн зөвшөөрлийн үйлчилгээг цахимд шилжүүлсэн мэдээллийг 4 сонин, 20 сайт, 3 телевизээр, цахим визтэй холбоотой мэдээллийг 11 сайт, 2 телевизээр, оршин суух зөвшөөрлийн сунгалтын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн тухай мэдээллийг 21 сайтаар дамжуулан тус тус олон нийтэд хүргэлээ.</p> <p>“Шинэ сэргэлтийн бодлого ба эрх зүйн орчны танилцуулга” сэдвээр зохион байгуулсан зөвлөгөөн, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулсан “Гадаадын ажиллах хүч, цахим виз,</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>хөрөнгө оруулалт, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал солилцох нь” сэдэвт уулзалтын үйл ажиллагааг Монголын мэдээ суваг, Ийгл телевиз, NTV телевиз зэрэг 11 телевизээр сурталчилж, мэдээллийг gogo.mn, ikon.mn, zindaa.mn, zarig.mn, mnb.mn, ivoice.mn, updown.mn, 24tsag.mn зэрэг 20 орчим сайтад нийтлүүлэн англи хэлээр Монголын Үндэсний олон нийтийн телевизийн MNB World сувгаар нэвтрүүлсэн.</p> <p>Гадаадын иргэн, харьяатын газрын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн 3 минут 15 секундийн видео шторкийг 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/658 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлээ.</p> <p>Evisa.mn цахим системийн ажиллагаа, үйлчилгээний дарааллыг товч, ойлгомжтой байдлаар танилцуулсан 2 минут 42 секундийн видео шторкийг англи, монгол хэлээр нийт 7 сайтад нийтлүүлэв.</p> <p>Байгууллагын эрхлэх чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг тухай бүр тогтмол үнэн зөв мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайлбал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэдийн нутаг буцах асуудлаар 01 дүгээр сарын 10-ны өдөр Tug.mn мэдээллийн сайтад, нийгмийн сүлжээнд цацагдсан “Оросын Холбооны Улсын иргэд олноор орж иржээ” гэх мэдээлэлтэй холбоотойгоор 04 дүгээр сарын 25-ны</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>өдөр eguur.mn, SBN, TV6 телевизэд, гадаадын иргэдийн зөрчлийн мэдээллийг 05 дугаар сарын 02-ны өдөр peguun.mn сайтад тус тус нийтлүүлсэн.</p> <p>Мөн Эмээлтийн мах боловсруулах үйлдвэрүүдийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан 06 дугаар сарын 02-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан хэвлэлийн хуралд Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга оролцож, тайлбар мэдээлэл хийлээ.</p> <p>Оросын Холбооны Улсын иргэдэд түр оршин суух зөвшөөрөл олгох асуудлаар өгсөн ярилцлагыг 10 дугаар сарын 05-ны өдөр, Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх, гадаадын иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулах зорилгоор нэвтрүүлж буй цахим виз, хил орчмын аялал жуулчлалын виз, олон улсын хилийн боомтод олгох жуулчин ангиллын визийн талаар хүргэсэн ярилцлагыг 10 дугаар сарын 07-ны өдөр ikon.mn, gogo.mn, tsahiur.mn, news.mn, zuv.mn, zindaa.mn зэрэг 15 сайтаар олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Мөн байгууллагын дарга “Vip Expert” сэтгүүлийн 2022 оны намрын дугаарын “Vip зочин” буланд цахим шилжилтийн үйл явц, үр дүн, хэтийн зорилгын талаар ярилцлага нийтлүүлэв.</p> <p>Виз, зөвшөөрлийн газрын дарга Монгол HD телевизийн 10 дугаар сарын 10-ны өдрийн “Нүүдэл шийдэл” хэлэлцүүлэгт Оросын Холбооны Улсын иргэдийн виз, оршин суух</p>	

1	2	3	4	5	6	7	8
						зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар, 10 дугаар сарын 26-ны өдөр “Монголын мэдээ” сонинд Монгол Улсад түр ирсэн болон иргэд харилцан зорчих нөхцөл, гадаад иргэдийн виз, визтэй холбоотой асуудлаар тус тус ярилцлага өглөө.	
34	Гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн хадгаламжийн баримтыг бий болгох	Урсгал зардлаар	- Кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн баримтын данс бүртгэлийг цэгцэлж үүсгэсэн огноо; Хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар удирдлагад танилцуулсан тайлан, илтгэх хуудасны дугаар, огноо.	-	Эхний хагас жил, жилийн эцэст: Кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн баримт данс, бүртгэлтэй болсон байна.	2018-2021 оны байгууллагын үйл ажиллагаанд холбогдох кино, гэрэл зургийн 206 хавтас бүхий 7648 файл буюу дижитал цахим баримтыг хүлээн авч, 2012-2021 оны нийт 485 хавтас бүхий 25982 гэрэл зураг, дүрс бичлэгийн баримт (файл)-ыг үүсгэн архивын сан хөмрөгийг баяжуулав.	100
35	Цахим хэлбэрт шилжүүлэх баримтын жагсаалт үйлдэж, Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах	Урсгал зардлаар	- Баримт нягтлан шалгах комисс хуралдсан огноо, шийдвэрлэсэн асуудал; - Цахим архивын сан үүсгэх төлөвлөгөөний	Байгууллагын архивын нийтлэг журам"-ын 8.1-т заасны дагуу “Цахим мэдээллийн сан”-д баяжилт хийсэн. Үүнд: Байгууллагын эхний хагас жилд 2013-2014 оны 42 хадгаламжийн нэгж, сүүлийн хагас жилд 2014-2017 оны 285 хадгаламжийн нэгжийг “е-архив” программд	Эхний хагас жил, жилийн эцэст: Цахим санг төлөвлөгөөний дагуу тогтмол баяжуулсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын нийтлэг журам”-д заасны дагуу архивын 2018-2020 оны цахим хэлбэрт шилжүүлэх 565 хадгаламжийн нэгжийн жагсаалтыг “Баримт нягтлан шалгах комисс”-ын хурлаар хэлэлцүүлж, 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан. Бүртгэлд 2018-2020 оны байнга хадгалах 278 хадгаламжийн нэгжийг бүртгэж, 242 хадгаламжийн нэгжийг	100

1	2	3	4	5	6	7	8
			батлагдсан огноо; Цахимд шилжүүлсэн баримтын тоо, нэр, төрөл.	холбосон. 2021 онд 2013-2017 оны 285 хадгаламжийн нэгжийн 114235 хуудас баримтын 96749 иргэний баримтыг овог нэрээр е-архив программд холбосон. 2013-2017 оны Цахим баримтын 565 хадгаламжийн нэгжид бүртгэл үйлдсэн.		цахим хэлбэрт шилжүүлэн 181 хадгаламжийн нэгжийн баримтыг е-архив программд холбов.	
Хэсгийн дундаж хувь: 100							
Зорилт 5. Байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөн, тайлагнах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах							
36	Гадаад харилцааг хөгжүүлэх дунд хугацааны бодлогын хөтөлбөр боловсруулах	Урсгал зардал	- Бодлогын баримт бичгийн батлагдсан огноо; Хэрэгжилтийн тайлан.	-	Эхний хагас жилд: Гадаад харилцааны дунд хугацааны бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж, судалгаа хийн удирдлагад танилцуулсан байна. Жилийн эцэст: бодлогын баримт бичгийг батлуулж, хэрэгжүүлсэн байна.	Европын Холбооны Улсууд болон Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн урт, дунд хугацааны хөтөлбөрийг харьцуулан судалж, Гадаадын иргэн, харьяатын газрын “Гадаад харилцааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан. Төслийг 12 дугаар сарын 07-ны өдрийн 09/17 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж, 12 дугаар сарын 16-ны өдрийн А/228 дугаар тушаалаар батлуулав.	100
37	Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилт гаргах	Урсгал зардал	- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/150 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар “Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги	Жилийн эцэст: Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилсан байдлаар гаргаж, 2023 оны 2 дугаар сарын 01-	“Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр баталсан “Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны хяналт-	100

1	2	3	4	5	6	7	8
			<p>хэлэлцүүлсэн огноо; - Холбогдох байгууллагад хүргүүлсэн албан бичгийн дугаар, огноо.</p>	<p>төлөвлөгөө” батлагдсан. Байгууллагын даргын 2021 оны А/134 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацааг тодорхой тусгав.</p>	<p>ний өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бэлтгэн, удирдлагад танилцуулсан байна.</p>	<p>шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө”-д тусгаснаар 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тайлагнана.</p>	
38	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг гаргах	Урсгал зардал	<p>- Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн огноо; - Батлагдсан огноо; - Биелэлт гаргаж, даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн огноо; Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн албан</p>	<p>Засгийн газрын 2021 оны 218 дугаар тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар баталсан загварын дагуу байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/92 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчаар баталгаажуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус байгууллагад ирүүлсэн.</p>	<p>Эхний хагас жилд: Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн батлуулсан байна. Жилийн эцэст: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил, жилийн эцсийн биелэлтийг холбох хугацаанд нь гарган даргын дэргэдэх</p>	<p>Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн саналыг “Даргын дэргэдэх зөвлөл”-ийн 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01/134 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулан, хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 07 дугаар сарын 08-ны өдөр танилцууллаа. 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг “Даргын дэргэдэх зөвлөл”-ийн 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/2215 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
39	“Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Урсгал зардал	- Батлагдсан төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт.	Байгууллагын зүгээс авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан байгууллагын даргаар 2021 оны 3 дугаар сард батлуулсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлэв.	Эхний хагас жил: “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-г батлуулах Жилийн эцэст: Албан хаагчийг сургалтад хамруулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 01 дүгээр сарын 24-ний өдөр тус тус батлан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Орон нутаг дахь газрын салбар эрх бүхий албан тушаалтнуудад 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/761 дүгээр албан бичгээр төрийн захиргаа, төрийн үйлчилгээний мэдүүлэг гаргагч албан хаагчдын “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бүртгэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг хүргүүлж, 43 албан хаагчийн мэдэгдэл, тайлбарыг “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем”-д бүртгэсэн. Мэдүүлэг гаргагч нийт 201 албан тушаалтны 2021 оны шинэчлэн гаргасан мэдүүлгийг хуулийн хугацаанд нь бүртгэж, “ХАСХОМ-ийн	100

1	2	3	4	5	6	7	8
						2022 оны тайлан"-г Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 126 албан хаагчийг хамрууллаа.	
40	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Урсгал зардал	- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.	Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангах	Эхний хагас жилд: Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлсэн байна. Жилийн эцэст:	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02/184 дүгээр, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг мөн өдрийн 02/185 дугаар албан бичгээр тус тус Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. Байгууллагын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2022 оны төлөвлөгөө"-г баталж, зохион байгуулалтын нэгжүүдэд танилцуулан, хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 29-ний өдрийн 03/1207 дугаар албан бичгээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 16 ажил төлөвлөснөөс төлөвлөгөөний хэрэгжилт 85.0 хувьтай байна. Төлөвлөгөөнд тусгаснаар жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 26-ны өдөр холбогдох байгууллагад тайлагнасан.	100
41	Гамшгаас хамгаалах хууль	Урсгал зардал	- Бүх нийтийн болон	Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн	Эхний хагас жил, жилийн эцэст:	Улсын онцгой комиссын 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр	100

1	2	3	4	5	6	7	8
	<p>тогтоомжийн хэрэгжилтийг хангах</p>		<p>өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зохион байгуулсан ажлын тоо; - Хамрагдсан нэгж, албан хаагчийн тоо.</p>	<p>байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байгууллагын Гамшгаас хамгаалах шуурхай штабын үйл ажиллагааг зохион байгуулж, Засгийн газар болон Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх</p>	<p>Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байгууллагын Гамшгаас хамгаалах шуурхай штабын үйл ажиллагааг зохион байгуулж, Засгийн газар болон Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>хуралдааны 1.3-т заасан албан байгууллагууд коронавируст халдвар (КОВИД-19) тархах, хүний нөөцийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх” тухай шийдвэр, Засгийн газрын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Халдварын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг тус тус хангах ажлын хүрээнд хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллуулан, хилийн боомт орон нутаг дахь нэгжээс өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг авч, нэгтгэн цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Улсын онцгой комиссын 01 дүгээр тогтоолоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтын “Шар түвшин”-д 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын төв, орон нутагт ажиллаж буй хариуцлагатай эргүүл, жижүүрийн үйл ажиллагааг түр зогсоож, “Ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг тогтмол сахиулж, халдваргүйжүүлэлт тогтмол хийх, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах тухай” 02/214 дүгээр албан бичгийг зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлээ. Дархлаажуулалтын 1, 2 дугаар тунд нийт 258, дархлаа сэргээх 3 дугаар тунд нийт 123 албан хаагч хамрагдсан байна.</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>Улсын Онцгой Комиссын 02 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.1-т заасны дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоож, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн үүргийг цахим хэлбэрээр зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлсэн. Мөн ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын багаас ирүүлсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдлын мэдээг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахиулах үүрэг бүхий албан хаагчдад цахим хэлбэрээр тухай бүр тогтмол хүргүүлж ажиллав.</p> <p>Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай” А/467 дугаар захирамжийн хүрээнд байгууллагын “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийг зохион байгуулж, албан хаагчдаа бүрэн хамруулсан.</p> <p>Улсын онцгой байдлын ерөнхий газраас 06 дугаар сарын 03-аас 05-ны өдрүүдэд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг “Онц” дүнтэй амжилттай хэрэгжүүллээ.</p> <p>Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны “Хаан шонхор-2022” гурав дахь удаагийн нэгдсэн дадлага сургуулийн арга хэмжээний зохион байгуулалтад 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд оролцов.</p> <p>Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын нэрэмжит 2022 оны “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах”</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>тухай А/59 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-т Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид амжилттай оролцож, “Дүүрэн хангалттай” дүгнэгдлээ.</p>	
42	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарих</p>	Урсгал зардал	-Тарьсан модны тоо.	<p>Эх дэлхий байгаль орчноо хамгаалах зорилгоор зохион байгуулагдаж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, тарих модны хэмжээ_санхүүгийн тооцооллын талаар санал бэлтгэн 2021 оны 10 сарын 03-ны өдрийн 03/1517 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	<p>Эхний хагас жилд: шаардлагатай төсвийг батлуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Зохион байгуулалтын нэгжүүд холбогдох төлөвлөгөөний дагуу мод тарьсан байна.</p>	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй “Ногоон Ази” төрийн бус байгууллагын дэмжлэгээр 300 модны суулгацыг хүлээн авсан. Орон нутаг дахь нэгжүүд харьяалах нутаг дэвсгэртээ нийт 6 төрлийн 575 ширхэг мод тарьж, тогтмол усалгаа, арчилгааг хийж байна. Үүнээс онцолбол, Хойд бүс дэх газар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг дэвсгэрт 22500 м2 газрыг хашаалж байгууллагын нэрэмжит төгөл байгуулан 4 төрлийн 165 ширхэг мод (агч 50 ширхэг, монос 30 ширхэг, интоор 25 ширхэг, үхрийн нүд 60 ширхэг) тарьж арчилж байна. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин Агаарын замын боомт хариуцсан газраас Төв аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран тус газрын нэрэмжит төгөл байгуулах ажлыг эхлүүлээ.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
43	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах	Урсгал зардал	- Хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албыг виз, зөвшөөрөл, иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр сар, хагас, бүтэн жилийн тайлан, танилцуулах тойм мэдээгээр, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын талаар улирал тутам мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Холбогдох мэдээ, мэдээллийг хугацаанд нь, алдаагүй, үнэн зөв Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэн ажилласан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч, цагаач, харьяалалгүй хүний талаарх судалгаа, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2021 оны дөрөвдүгээр улирлын танилцуулах тойм мэдээ, 12 дугаар сарын үндсэн үйл ажиллагааны мэдээ, 2022 оны эхний хагас жил, 01-06 дугаар сард хэрэгжүүлсэн үндсэн үйл ажиллагааны мэдээ, 2022 оны 3 дугаар улирлын танилцуулах тойм мэдээ, нийт 11 удаагийн тайлан, мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлж, мэдээллээр ханган ажиллалаа. Түүнчлэн журмын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 01/291, 01/354, 01/440, 01/485, 01/589, 01/687, 01/785, 01/874, 01/944, 01/1035, 01/1132, 01/1235, 01/1320, 01/1373, 01/1462 01/1543, 01/1634, 01/1712, 01/1804, 01/1897, 01/1976, 01/2066 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн. Байгууллагад холбогдох хэсгийн 1, 2, 3, 4 дүгээр улирлын танилцуулах мэдээг 01/580, 03/1190, 01/1676, 01/2186 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.	100

1	2	3	4	5	6	7	8
44	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх; - Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг танилцуулах 	Засгийн газрын холбогдох журамд заасан хугацаанд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнан ажилласан.	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 49 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг холбогдох дээд шатны байгууллагад албан бичиг болон “Төрийн мэдээллийн сүлжээ” систем (mojha.unelgee.gov.mn)-ээр тайлагнаж ажиллалаа.	100
45	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтэд болон зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянасан огноо; - Байгууллагын болон зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагад танилцуулсан огноо. 	Засгийн газрын холбогдох журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлт болон зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, үр дүн, тайланг удирдлагад танилцуулан ажилласан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ,	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 07 дугаар сарын 08-ны өдөр удирдлагад тус тус танилцуулсан. Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийн, үнэлгээг 2021 оны 12 дугаар сард 01-09/33 дугаар илтгэх хуудсаар, 2022 оны эхний хагас жилийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийн тайланг 07 дугаар сарын 06-ны өдөр тус тус удирдлагад танилцууллаа.	100

1	2	3	4	5	6	7	8
					үнэлгээг хийсэн байна.		
46	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	Урсгал зардал	- Эрсдэлийн үзүүлэлт, хариу хэмжээний хэрэгжилт.	Байгууллагын зорилго, зорилтуудыг хангахад учирч болох нөлөөллийн хор хөнөөл, саад, үйл ажиллагааг доголдоход хүргэдэг үр дагаврыг тодорхойлох үүднээс 2021 оны эрсдэлийн тайланд оруулах саналыг 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09/08 дугаартай дотоод албан хүргүүлэн саналыг авч, тайланг удирдлагад танилцуулсан.	Жилийн эцэст: Байгууллагын үйл ажиллагаанд учирч болохуйц тодорхойлсон эрсдэлийг ач холбогдлоор нь зэрэглэж, эрсдэлийн үнэлгээг хийж, тайланг удирдлагад танилцуулан, эрсдэлийг сааруулах буюу бууруулах арга хэмжээ авсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1/1856 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны үнэлгээ, эрсдэлийг “Даргын дэргэдэх зөвлөл”-ийн 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралд танилцуулж, 05 дугаар сарын 06-ны өдөр “Эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Байгууллагын 2021 оны эрсдэлийн тайланг 12 дугаар сард 01/1747 дугаар, 2022 оны эхний хагас жилийн эрсдэлийн тайланг 06 дугаар сард 01/1135 дугаар, 2022 оны эрсдэлийн тайланг 12 дугаар сард 01/2087 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, эрсдэлийн мэдээллийн цахим сан (mojha.unelgee.gov.mn)-д эрсдэлийг үнэлж, тайлагнан баталгаажуулсан.	100
47	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	Урсгал зардал	- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан тоо, өгсөн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 3 удаагийн удирдамжийн дагуу төв болон орон нутаг дахь нэгжүүдийн 2020 оны IV, 2021 оны I-III дугаар улирлын байдлаар сайтад байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийж, үр дүнг байгууллагын удирдлагад 01-09/15, 01-09/20, 01-09/27 дугаар бүхий илтгэх хуудсаар танилцуулсан. Шилэн	Эхний хагас жил, жилийн эцэст: Шилэн дансны хуульд хяналт тавьж хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулалтын нэгжүүдийн www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан сар тутмын мэдээлэлд хяналт тавьж, байгууллагын даргын 4 удаагийн удирдамжийн дагуу 2021 оны 4 дүгээр улирал, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын хэрэгжилтэд аудит хийн, дүнг 01-10/01, 01-10/07, 01-10/13, 01-09/15 дугаар илтгэх хуудсаар танилцуулж, зохион байгуулалтын нэгжүүдэд 4 удаагийн зөвлөмж хүргүүлэн, биелэлтийг хангуулан ажиллалаа.	100

1	2	3	4	5	6	7	8
				дансны тухай хуулийн хэрэгжилтийн тоон үзүүлэлт 2021 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагын хэмжээнд 96.8 хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар заавар, зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.			
48	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”, захиргааны мэдээллийн маягт, түүнийг нөхөх заавар”-ын хэрэгжилтийг ханган ажиллах	Урсгал зардал	- Хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар.	Хууль зүй, дотоод хэргийн яамыг гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2019, 2020 оны харьцуулсан мэдээ, 2020 оны 12, 2021 оны 01-11 дүгээр сар, хагас бүтэн, бүтэн жилийн нийт 12 удаагийн мэдээг 11 удаагийн албан бичгээр хүргүүлэн мэдээ мэдээллээр хангаж ажилласан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Холбогдох журмын дагуу хугацаанд нь мэдээллийг үнэн, зөв хүргүүлсэн байна.	Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020, 2021 оны харьцуулсан мэдээ, 2021 оны 12 дугаар сар, 2021 болон 2022 оны эхний хагас жилийн харьцуулсан мэдээ, 2022 оны 01-11 дүгээр сарын нийт 14 статистикийн мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж, мэдээллээр ханган ажиллалаа. Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмууд шинэчлэн батлагдсантай холбогдуулан статистикийн мэдээлэл, судалгааны маягтад өөрчлөлт оруулах тухай саналыг 03 дугаар сарын 15-ны өдрийн 3/514 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100
49	Нийцлийн болон санхүүгийн аудит хийж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудитыг зохион байгуулж	Урсгал зардал	- Хяналт, шалгалтын тоо, эрсдэлийн үзүүлэлт.	Төсөв, санхүүгийн чиглэлээр 4, нийцлийн аудитын чиглэлээр 2 нийт 6 удаагийн /төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус/ дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд	Эхний хагас жил, жилийн эцэст: Байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөний дагуу ажиллаж, үр дүнг удирдлагад	Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр 3, нийцлийн чиглэлээр 7, нийт 10 удаагийн төлөвлөгөөт аудитыг хийж, төв болон орон нутаг дахь нэгжүүдэд 7 удаагийн зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтийг ханган ажиллах			холбогдох газар, хэлтэст, албан тушаалтанд илэрсэн зөрчлийг засаж ажиллах талаар заавар, зөвлөгөө өгч, нийт 2 зөвлөмжийг холбогдох газруудад тухай бүр хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажилласан.	танилцуулсан байна.	<p>- Төсөв санхүү, үйл ажиллагааны чиглэлээр:</p> <p>Байгууллагын даргын 3 удаагийн удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын 2021 оны хүний нөөцийн үйл ажиллагаа, Дорноговь аймаг дахь газар, Өмнөд бүс дэх газрын 2021 он, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, дүнг 01/10/04, 01-10/08, 01-09/16 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж, тайлагнав.</p> <p>Захиргаа, удирдлагын газарт 03 дугаар сарын 17-ны өдрийн 10/15 дугаар, Дорноговь аймаг дахь газарт 05 дугаар сарын 09-ний өдрийн 10/32 дугаар дотоод албан бичгээр, Өмнөд бүс дэх газарт 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/2038 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, хяналт тавьсан.</p> <p>- Нийцлийн чиглэлээр:</p> <p>Байгууллагын даргын 3 удаагийн удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын 2021 оны хүний нөөцийн үйл ажиллагаа, Дорноговь аймаг дахь газар, Өмнөд бүс дэх газрын даргын 2021 он, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг 01/10/04, 01-10/08, 01-09/16 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж, тайлагнав.</p>	
50	Байгууллагын үйл ажиллагааны 2001-2021 оны статистик	Урсгал зардал	- Статистик мэдээний эмхэтгэл гаргасан огноо,	Байгууллагын үйл ажиллагааны 2001-2020 оны статистик тоон мэдээллийн эмхэтгэлийг нэгтгэн боловсруулж,	Жилийн эцэст: Байгууллагын 2001-2021 оны нэгдсэн статистик	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2001-2021 оны тоон мэдээллийг багтаасан статистикийн эмхэтгэлийг нэгтгэн гаргаж, байгууллагын вэб хуудаст байршуулан	100

1	2	3	4	5	6	7	8
	эмхэтгэлийг гаргах		хэвлүүлсэн тоо.	2021 оны 11 сарын 24-ний өдөр 40 ширхгийг хэвлүүлэн, зохион байгуулалтын 13 нэгжийн албан хаагчид тараан, албан хэрэгцээнд ашиглаж байна.	мэдээний эмхэтгэл хэвлэгдэн гарсан байна.	хэвлэмэл хувилбарыг албан хэрэгцээнд ашиглах зориулалтаар зохион байгуулалтын 16 нэгжид хүргүүлсэн.	
51	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг төрөлжүүлэн гарын авлага гаргах	Урсгал зардал	- Төв, орон нутаг дахь хяналтын улсын байцаагчдыг гарын авлагаар хангасан тоо.	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг төрөлжүүлэн гарын авлага эхийг зөвхөн бэлтгэсэн.	Эхний хагас жил, жилийн эцэст: Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг төрөлжүүлэн гарын авлагыг бэлтгэн, албан хаагчдыг мэдээллээр хангасан байна.	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг төрөлжүүлэн гарын авлагыг бэлтгэсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан гарын авлагын цахим хувилбарыг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчдад хүргүүлж, 12 дугаар сарын 09-ний өдрийн 05/63 дугаар дотоод албан бичгээр баталгаажууллаа.	100
Хэсгийн дундаж хувь: 100							
Зорилт 6 . Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний зорилт 4)							
52	Ижил төрлийн чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох	Гаднын хандив туслалцаа	Хамрагдсан албан хаагчийн тоо, хийсэн айлчлалын тоо.	“Ковид 19” халдварт цар тахлын нөхцөл байдлын улмаас гадаад хамтын ажиллагааны арга хэмжээнүүд зогссон.	Эхний хагас жилд: БНСВУ, ТУРК, БНХАУ-д байгууллагын төлөөлөгчдийн хийх албан айлчлалыг зохион байгуулсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, байгууллагын даргын хамт энэ оны 3 дугаар улиралд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад албан айлчлал хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан бэлтгэл хангах ажлын хүрээнд тус улсын НАБЯ-ны харьяа Шилжилт хөдөлгөөний удирдах газартай байгуулах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн альтернативын	100

1	2	3	4	5	6	7	8
					<p>Жилийн эцэст: Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаатай танилцах айлчлал туршлага солилцох үйл ажиллагаанд 10-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна.</p>	<p>талаар 02 дугаар сарын 10-ны өдөр Гадаад харилцааны яаманд цахим шуудан хүргүүлсэн. Байгууллагын дарга албаны холбогдох 9 төлөөллийн хамт Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт 05 дугаар сарын 23-аас 27, Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын байгууллагад 06 дугаар сарын 26-аас 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд хийсэн албан айлчлалаар олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, 2 улсын цагаачлал, шилжилт хөдөлгөөний байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр ажиллалаа. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны намын дарга бөгөөд тэргүүн дэд сайдтай 04 дүгээр сарын 26-ны өдөр хийсэн цахим уулзалтад байгууллагын дарга холбогдох албан тушаалтны хамт оролцож, хоёр орны хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцлоо.</p>	
53	БНХАУ-ын Шилжилт хөдөлгөөний удирдах газрын удирдлага болон БНТУ-ын Дотоод хэргийн яамны харьяа Шилжилт, хөдөлгөөний ерөнхий газрын	Урсгал зардал	- Хийсэн айлчлалын огноо, үр дүн.	“Ковид 19” халдвар цар тахлын нөхцөл байдлын улмаас гадаад хамтын ажиллагааны арга хэмжээнүүд зогссон.	Эхний хагас жилд: Айлчлалын бэлтгэл ажлыг хангасан байна. Жилийн эцэст: Айлчлалыг амжилттай зохион	Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны намын дарга бөгөөд тэргүүн дэд сайдтай 04 дүгээр сарын 26-ны өдөр хийсэн цахим уулзалтад байгууллагын дарга холбогдох албан тушаалтны хамт оролцож, хоёр орны хууль сахиулах байгууллагын хамтын	100

1	2	3	4	5	6	7	8
	<p>удирдлага тус байгууллагын үйл ажиллагаатай танилцах айлчлалыг зохион байгуулах</p>				<p>байгуулсан байна</p>	<p>ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцлоо. Дээрх арга хэмжээний үр дүнд хоёр орны 2016 онд байгуулсан “Санамж бичиг”-ийг шинэчлэн байгуулах, тус улсад албан айлчлал хийх тухай саналыг 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1047 дугаар албан бичгээр Нийгмийг аюулаас хамгаалах яамны Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэв.</p> <p>Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Үндэсний удирдах газраас Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн төслийг хянуулахаар 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1920 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, зөвшөөрөл авлаа.</p> <p>Байгууллагын дарга холбогдох албан тушаалтнуудын хамт Бүгд Найрамдах Турк Улсад 05 дугаар сарын 23-аас 27-ны өдрүүдэд хийсэн албан айлчлалаар олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол, Туркийн Цагаачлал, шилжилт хөдөлгөөний байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр албан уулзалтуудыг зохион байгууллаа.</p> <p>Айлчлалын хүрээнд төлөөлөгчид Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (TIKA)-т зочлохдоо байгууллагад өрнөж буй цахим шинэчлэлийн хүрээнд мэдээлэл, технологийн шинэлэг шийдлүүдийг үйлчилгээнд нэвтрүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх</p>	

1	2	3	4	5	6	7	8
						чиглэлээр хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн.	
54	Гадаад улсын Олон улсын байгууллагатай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Гаднын хандив, туслалцаа	- Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн.	“Ковид 19” халдвар цар тахлын нөхцөл байдлын улмаас гадаад хамтын ажиллагааны арга хэмжээнүүд зогссон.	Эхний хагас жилд: Төсөл, хөтөлбөрийн бэлтгэл ажлыг хангасан байна. Жилийн эцэст: Төсөл, хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан байна.	<p>Байгууллагын үндсэн чиглэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн болон нэмэлт программыг байршуулах, мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх, Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх төхөөрөмж нийлүүлэх зорилгоор төсөл боловсруулан 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/582 дугаар албан бичгээр Бүгд Найрамдах Турк Улсын ТИКА-ийн Улаанбаатар дахь хөтөлбөрийн зохицуулагчид хүргүүлсэн. Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (ТИКА)-аас 08 дугаар сарын 09-ний өдөр байгууллагад 69,980 ам. долларын өртөг бүхий тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар хүлээлгэн өглөө.</p> <p>Байгууллагын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгчтэй 2007 оноос хойших хоёр байгууллагын хамтын ажиллагаа болон олон улсын жишигт нийцсэн программ хангамж, техник технологи, цахим гарцыг амжилттай нэвтрүүлсэн асуудлаар 02 дугаар сарын 22-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулав.</p> <p>Уулзалтаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас 2023-2025 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийг онцлон 2023 оноос хэрэгжүүлэх талаар санал солилцлоо.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
55	Ижил чиг үүргийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааг идэвхжүүлэх	Урсгал зардал	- Харилцан солилцсон мэдээллийн тоо, хэрэгжилт, үр дүн.	“Ковид 19” халдвар цар тахлын нөхцөл байдлын улмаас гадаад хамтын ажиллагааны арга хэмжээнүүд зогссон.	Санамж бичиг, хамтарсан мэдэгдэл хэлэлцээрт заасны дагуу холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол солилцож хэвшсэн байна.	<p>Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын НАБЯ-ны харьяа Шилжилт хөдөлгөөний удирдах газартай байгуулах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн альтернатын талаар 02 дугаар сарын 10-ны өдөр Гадаад харилцааны яаманд цахим шуудан илгээсэн.</p> <p>Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай харилцан ойлголцлын “Санамж бичиг” байгуулах тухай хүсэлтийг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/587 дугаар албан бичгээр тус улсын Нийгмийн аюулаас хамгаалах яамны харьяа Цагаачлалын албанд мөн хүргүүлэв.</p> <p>Монгол Улсын иргэд олноор оршин суудаг орнуудын гадаадын иргэн, харьяат, цагаачлалын байгууллагуудтай холбоо тогтоож, хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Цагаачлалын байгууллагатай хамтран ажиллах тухай “Санамж бичиг”-ийн төслийг 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/647 дугаар албан бичгээр Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчид сайдад хүргүүлсэн.</p> <p>“Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Киргиз Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-ний төсөлд тусгах саналыг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/588 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						газартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх саналыг уламжлуулахаар 01/581 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүсэлт хүргүүлээ. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журам, байгууллагын үйлчилгээний мэдээлэл болон гадаадын иргэдэд зориулсан санамжийг 04 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 24 Дипломат төлөөлөгчийн газарт цахим хэлбэрээр хүргүүлэв. Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Финланд Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай байгуулсан санамж бичгийн хүрээнд “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийг тухайн улсын хэлнээ хөрвүүлэн 09 дүгээр сарын 12-ны өдөр цахим хэлбэрээр илгээсэн.	
Хэсгийн дундаж хувь: 100							
Зорилт 7 . Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах							
56	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөж батлуулах, зориулалтын дагуу зарцуулах	Урсгал зардал	- Төсвийг төлөвлөн батлуулж, зориулалтын дагуу зарцуулсан байх.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг боловсруулан нэгтгэж, тайлбар тодруулгын хамт Хууль зүй дотоод хэргийн яамд 2021 оны 01/1052 дугаар албан бичгээр хүргүүлж, 2022 оны төсвийг батлуулсан. 2021 онд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр авлага үүсгээгүй ажилласан.	Эхний хагас жилд: Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. Сүүлийн хагас жилд: Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн саналыг 2022 оны 01/728 дугаар, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарт тусгах саналыг нэгтгэн 2022 оны 01/901 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. 2022 онд 9,108.8 сая төгрөгийн төсөв батлагдан 01, 05 дугаар саруудад төсөвт тодотгол хийснээр нийт 648.4 сая төгрөгийн төсөв хасагдаж, 8,460.4 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байна.	100

1	2	3	4	5	6	7	8
						Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 04, 06, 09, 10, 11, 12 дугаар сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн холбогдох санхүүжилтийг шийдвэрлүүлж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллалаа.	
57	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансыг нэгтгэн, холбогдох байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах.	Урсгал зардал	- Нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийсэн огноо, дүгнэлт.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж Үндэсний аудитын газарт 2021 оны 01/330 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний аудитын газрын хяналт шалгалтад амжилттай шалгуулж, “Зөрчилгүй” дүгнэлт авч ажилласан. Энэ оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг тайлбар тодруулгын хамт 2021 оны 01/1021 дүгээр албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж нэгтгүүлсэн болно	Эхний хагас жилд: 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа зөрчилгүй дүгнэгдсэн байна. Сүүлийн хагас жил: Байгууллагын 2 дугаар улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.	Төсвийн шууд захирагчдын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тухайн орон нутгийн харьяа Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар нэгжүүд “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилласан. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/457 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт, 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/578 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүллээ. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт гаргасныг 2022 оны 01/709 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газраас ирүүлж, танилцууллаа.	100
58	Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Худалдан авах ажиллагааны 2022 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан	1,780.3 тэрбум	- Тендерийн тоо, зарласан хугацаа, шалгарсан байгууллага тай хийсэн гэрээ, түүний огноо, гэрээг	Байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 4 төрлийн 621.8 сая төгрөгийн тендер зарлаж, 7 байгууллагатай гэрээ	Эхний хагас жилд: Хуулийн дагуу зохион байгуулж, шалгарсан бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээг байгуулан	2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-д нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн Сайдын А/118 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “2022 оны худалдан авах ажиллагааны	100

1	2	3	4	5	6	7	8
	<p>авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллах</p>		<p>дүгнэсэн хугацаа.</p>	<p>байгуулсан. 2021 оны худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тухай бүр тайлагнаж ажилласан. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 202101/1608 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	<p>гүйцэтгэлийг хангаж, гэрээг дүгнэсэн байна. Сүүлийн хагас жилд: Холбогдох тайлан мэдээ, дараа жилийн төлөвлөгөөг боловсруулах</p>	<p>төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны худалдан авах ажиллагаанд 6 төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөснөөс хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг тухай бүр зохион байгуулж, хагас жилийн байдлаар 5 байгууллагатай гэрээ байгуулсан. Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын ажил гүйцэтгэх, Багаж техник хэрэгсэл нийлүүлэх, Сувагчлал, Мэдээлэл технологийн үйлчилгээ, Нормын хувцас нийлүүлэх, Шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, гэрээ байгуулан үр дүнг tender.gov.mn сайтад байршуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллалаа. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай саналыг энэ оны 01/375, 01/902 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлж цахим системд өөрчлөлтийг байршуулсан. 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг А/2098 дугаар, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 01/1981 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлж ажиллав. Худалдан авах ажиллагааны үр дүнг tender.gov.mn болон www.publicinvestment.gov.mn сайтын PIMIS программд тус тус бүртгэлээ. Сангийн яамны www.publicinvestment.gov.mn сайтын</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>PIMIS программд Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барих барилгын ажил гүйцэтгэх гэрээг байршуулсан.</p> <p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Саммит компьютер технологи” ХХК-аас 58 ширхэг техник хэрэгсэл, компьютер, “Батзүү” ХХК-аас 4 төрлийн 487 ширхэг нормын хувцсыг тус тус хүлээн авсан.</p>	
59	<p>Тэмдэгтийн хураамжийн орлого, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавих, тайлан гаргах, үнэт цаасны тайланг нэгтгэх.</p>	Урсгал зардал	- Төвлөрүүлсэн орлогын дүн, тайлан нэгтгэсэн хугацаа.	<p>2021 оны 11 дүгээр сарын байдлаар тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн нийт 2,695.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан. Төв болон орон нутаг дахь нэгжийн үнэт цаасны тайланд хяналт тавьж, сар бүр нэгтгэл хийсэн.</p>	<p>Эхний хагас жилд: Тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, үнэт цаасны тайланг нэгтгэсэн байна. Сүүлийн хагас жилд: Тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, үнэт цаасны тайланг нэгтгэсэн байна.</p>	<p>Энэ оны 11 дүгээр сарын байдлаар байгууллагын хэмжээнд нийт 4,946.8 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 40.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, визийн үйлчилгээний хөлсний орлого болох нийт 166.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.</p> <p>Орон нутаг дахь нэгжүүдийн орлого төвлөрүүлэлтэд тогтмол хяналт тавьж, тулгалт хийн үнэт цаасны тайланг сар бүр нэгтгэн ажилласан.</p>	100
60	<p>Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл</p>	Урсгал зардал	- Байгууллагын эд хөрөнгийн тоо, үнийн дүн, тооцоо нийлсэн акт, бараа материал, эд	<p>ТӨБЗГ-ын 2021 оны 428 тогтоолын дагуу 5 автомашиныг холбогдох орон нутаг газрын тайлан бүртгэлд тусгасан. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн</p>	<p>Эхний хагас жилд: Тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулж, хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж үр</p>	<p>Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хагас, бүтэн жилээр зохион байгуулж, орон нутаг дахь нэгжүүдийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 449,</p>	100

1	2	3	4	5	6	7	8
	хөтлөлт, тайлан тэнцлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах.		хөрөнгийн тайлан.	хөрөнгийг актлуулах саналыг Хууль, зүй дотоод хэргийн яамны 2021 оны 01/1524 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8,299.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,095.9 сая төгрөгийн бараа материал тоологдсон.	дүнг тайланд тусгасан байна Сүүлийн хагас жилд: Тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулж, хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж үр дүнг тайланд тусгасан байна	A-1/1737 дугаар тогтоолд зааснаар эд хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан.	
Хэсгийн дундаж хувь: 100							
Зорилт 8. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллана.							
61	Албан хаагчдыг орон байртай болгох арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв	Албан хаагчдын амьдрах барилга барих асуудлаар хэлэлцсэн болон зохион байгуулсан арга хэмжээний тоо, огноо.	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр архивчдын гудамжинд шинээр барих “Архивын ерөнхий газар-Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын орон сууц”-ны төлөвлөлт хийх хэрэгцээний судалгаанд 131 албан хаагчийг хамруулсан. Судалгааны дүнгээр 45м2 талбайтай 1 өрөө байранд 5, -50-65м2 талбайтай 2 өрөө байранд 70, -60-90м2 3 өрөө байранд 56 албан хаагч санал өгсөн байна. Уг нийтийн орон сууцны инженерийн шугам сүлжээг бүхий газрыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас шийдвэрлэлээ.	Эхний хагас жилд: Барилга барих газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. Жилийн эцэст: Барилга барих хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт албан хаагчдын орон сууц барихаар төлөвлөсөнтэй холбогдуулан байгууллагын даргын 2022 оны А/16 дугаар тушаалаар “Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Нийслэлийн засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/15 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 5000 м.кв газрыг шийдвэрлүүлж, 05 дугаар сард Хууль, зүй дотоод хэргийн яамтай хамтран Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 оны ерөнхий төлөвлөгөөнд Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газрын албан хаагчдын орон сууцны барилга барих арга хэмжээг тусгуулан шугам сүлжээний ажилд 4.0 тэрбум төгрөгийг Нийслэлийн төсөвт батлууллаа. Барилгын ажил ковидын нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	100

1	2	3	4	5	6	7	8
62	Гадаадын иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх	Урсгал зардал	<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргах түвшинд холбогдох байгууллага, албан тушаалтантай уулзалт зохион байгуулсан огноо; - Харилцсан албан бичгийн огноо, дугаар; Шийдвэр гарч, эрх зүйн баримт бичиг батлагдсан эсэх. 	-	<p>Эхний хагас жилд: Гадаадын иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр мэргэжлийн, мэргэшсэн албан хаагчийг бэлтгэх зорилгоор Дотоод хэргийн их сургуультай хамтран ажиллах талаар хэлэлцсэн байна. Жилийн эцэст: Эрх зүйн баримт бичиг батлагдаж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үндэс, суурь тавигдсан байна.</p>	<p>Дотоод хэргийн их сургуульд “Эрх зүй-Гадаадын иргэн, харьяат судлал”-ын анги нээх хэрэгцээ, шаардлагыг судалж, дараах нөхцөлийг тодорхойлсон.</p> <p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн нийт 310 орон тоо батлагдсанаас 2022 оны 11 дүгээр сарын байдлаар төрийн захиргааны 289 албан хаагч ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан нийтлэг болон тусгай шаардлага хангасан, мөн хуулийн 23.4 дэх хэсэгт “Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална” гэж тус тус заасны дагуу албан тушаалын тодорхойлолтыг 2021 онд Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авч, байгууллагын даргын тушаалаар баталсан. Албан тушаалын тодорхойлолтод төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>хамаарах мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, хяналтын улсын ахлах байцаагч зэрэг албан тушаалд тавигдах тусгай шаардлагад “эрх зүй”, “олон улсын харилцаа” мэргэжлээр төгссөн байхаар тусгасан.</p> <p>Байгууллагын төрийн захиргааны албан хаагчийн 147 буюу 73.0 хувь нь эрх зүйч, 9 буюу 5.0 хувь нь олон улсын харилцаа, 45 буюу 22.0 хувь нь бусад мэргэжлийн албан хаагч бөгөөд насны ангиллаар 20-45 насны албан хаагч 84.0 хувийг эзэлж байна.</p> <p>Сүүлийн 3 жилийн дүнгээр хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг авч үзэхэд нийт 56 иргэн шинээр томилогдож, 40 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөний 32 буюу 57.1 хувийг төрийн захиргааны албан тушаалд томилсон бол 19 буюу 47.5 хувь нь чөлөөлөгдсөн, мөн 2020 онд 2 албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгджээ.</p> <p>Монгол Улсын их дээд сургуулиудад 2022 онд олон улсын харилцаа мэргэжлээр 714, эрх зүйчээр 3,722 оюутан суралцаж, мөн 2018-2020 онуудад зөвхөн эрх зүйч мэргэжлээр 7,603 мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. Иймд байгууллагын хүний нөөцийн шинжилгээ болон их, дээд сургуулиудыг “эрх зүйч”, “олон улсын харилцаа” мэргэжлээр төгсөгчид, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдсэн тоон мэдээлэлд үндэслэн Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн</p>	

1	2	3	4	5	6	7	8
						захиргааны албан тушаалын сул орон тоог их, дээд сургууль төгсөж, төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэгдсэн болон төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн тохиолдолд эсхүл бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн томилж нөхөх боломжтой байдлыг тус тус харгалзан Дотоод хэргийн их сургуульд тусгайлан “Эрх зүйч-Гадаадын иргэн, харьяат судлал”-ын анги нээж, хүний нөөц бэлтгэх шаардлагагүй тухай дүгнэлтийг гаргасан болно.	
63	Байгууллагын төв байр болон төв байрны гаднах зам, талбайн тохижилт, засварын ажлыг хийх	Урсгал зардал	- Хийгдсэн засвар, үйлчилгээний тоо, огноо.	2021 онд байгууллагын ариун цэврийн өрөө болон бусад өрөө тасалгааг засварлан тохижуулсан.	Эхний хагас жил, жилийн эцэст: Байгууллагын албаны байрны дулааны шугам, сүлжээг солих, засварлах ажлыг хийж, гадна зам талбай, хашааг засварласан байна.	Байгууллагын барилга, байгууламж, цэвэр, бохир ус, холбоо, цахилгаан, дулааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг ханган, тогтмол хяналт тавин ажиллаж байна. Улаанбаатар баруун түгээх станцаас ирж байгаа халаалтын даралтын доголдлыг арилгаж, дулааны үзелийн даралтын бойлерын гэмтлийг засварлан тухай бүр хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Автомашин 200 метр бетон замд хашлага (боржур) шинээр суулгах, автомашин зогсоолын цагаан шугам тодруулах, ногоон байгууламжийн хашлаганы шон, гадна талбайн хүлээлгийн сандлын өнгийг сэргээж будах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн 06 дугаар сарын 06-аас 10-ны өдрүүдэд байгууллагын ногоон байгууламжийн мод, бут, сөөгт	100

1	2	3	4	5	6	7	8
						тайралт хийж, өнгө үзэмжийг сэргээсэн.	
64	Өмнөд бүс дэх газрын албаны байрыг барьж ашиглалтад оруулах	Гаднын байгууллагын тусламж	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажлыг гүйцэтгэх талаар холбогдох байгууллагат ай хийсэн уулзалт, түүний огноо; - Барилгын гүйцэтгэлийн хувь, ашиглалтад орсон хугацаа. 	Барилгын гүйцэтгэл 50%	Эхний хагас жилд: Барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх талаар холбогдох талтай уулзалт зохион байгуулж, хэлэлцээр хийгдсэн байна. Жилийн эцэст: Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь нэмэгдсэн байна.	<p>Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 6 (Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллана)-ийн 6.8 дахь хэсэгт “Өмнөд бүс дэх газрын албаны байрыг барьж ашиглалтад оруулах” гэсэн 1 арга хэмжээ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас хөрөнгө оруулалтын явц шийдэгдээгүйн улмаас 50.0 хувьтай үнэлэгдсэн.</p> <p>Хоёр улсын яамд хоорондын 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны намын дарга бөгөөд тэргүүн дэд сайдтай 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын хамт байгууллагын дарга оролцов. Энэхүү уулзалтын хүрээнд тус улстай хиллэдэг боомтуудын дэд бүтцийг сайжруулах талаар харилцан санал солилцож, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан баримталж буй арга хэмжээний хориг цуцлагдсан даруй нэн шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ мэдэгдсэн болно.</p> <p>Түүнчлэн хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг шинэчлэн байгуулах асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны</p>	70

1	2	3	4	5	6	7	8
						<p>Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн хилээр орох гарахыг удирдах газрын даргатай 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтаар боомт, орон нутагт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл солилцож, тус барилгыг яаралтай ашиглалтад оруулахад дэмжлэг хүссэн.</p> <p>Цахим хэлбэрээр 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдах Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын 5 дугаар хуралдаанд байгууллагын төлөөлөл оролцож, дэд бүтцийн асуудлаар хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй холбоотой санал солилцох талаар харилцан тохиролцоод байгаа болно.</p>	
65	Хойд бүс дэх газрыг иргэдэд үйлчлэх үйлчилгээний байртай болгох	Азийн хөгжлийн банкны санхүү жилт	<ul style="list-style-type: none"> - Барилгын гүйцэтгэлийн хувь; - Ашиглалтад орсон огноо. 	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сэлэнгэ аймагт байрлах Сүхбаатар төмөр замын боомтын хажууд баригдах хил хяналтын байгууллагын дунд нэг цэгийн үйлчилгээний 6 давхар цогцолборын барилга баригдаж 95 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	<p>Эхний хагас жилд: Сүхбаатар төмөр замын боомтод баригдсан барилгын дулаан хангамжийг шийдэж, дотоод заслыг хийж, албаны байранд байрлах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар төмөр замын боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтаар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 3600м2 талбай бүхий 6 давхар “Нэг цэгийн үйлчилгээний цогцолбор”-ыг ашиглалтад оруулахад бэлэн боллоо. Хойд бүс дэх газар уг цогцолборын нийт 445.9м2 талбай бүхий 15 өрөө тасалгааг эзэмшихээр төлөвлөгдөж, техник хэрэгсэл, тавилга эд хогшил худалдан авахад шаардлагатай 49,435,000 төгрөгийг Сэлэнгэ аймгийн засаг даргын 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/475 дугаар захирамжаар</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас шийдвэрлүүлэн ажиллалаа.	
66	Баруун бүс дэх газрыг иргэдэд үйлчлэх үйлчилгээний байртай болгох	1 тэрбум	- Барилгын гүйцэтгэлийн хувь.	Баруун бүс газрын албаны байрны ТЭЗУ хийгдэж, төсөв батлагдсан	Эхний хагас жил, жилийн эцэст: Барилгын гүйцэтгэлийг 40 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын албаны байрыг шинээр барих төсвийг хөрөнгө оруулалтын төсөвт тусган, “2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв”-т батлуулснаар тендерийг 01 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар нээлттэй зарласан. Тендерт “Асиан сити” ХХК шалгарч, ГИХГ/202201010 тоот 2.389.789.123 төгрөгийн өртөгтэй “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г 03 дугаар сарын 30-ны өдөр байгууллаа. Гэрээг Сангийн яамны www.publicinvestment.gov.mn сайтын PIMIS программд байршуулсан. Нийт 3 давхар 1142,61 м.кв талбай бүхий тухайн барилга нь 1, 2 дугаар давхарт албаны өрөө, 3 дугаар давхарт албан хаагчдын амьдрах орон сууцны зориулалттай төлөвлөгдсөн. Барилгын ажлын явц 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 85.0 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
67	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн иргэдэд үйлчлэх үйлчилгээний байрыг барих газрын асуудлыг шийдвэрлэх	Урсгал засвар	- Газрыг байгууллагын нэр дээр шилжүүлж авсан гэрчилгээ; - УИХ-аас баталсан 2023 оны улсын төсвийн	Хууль зүй, дотоод хэргийн сайд Баян-Өлгий аймагт 2021 оны 5 дугаар сард албан ажлаар ажиллах үеэр тус хэлтэст 2022 оны улсын төсвөөр шинэ байр барьж өгөхөөр шийдвэрлэсэн. Энэ шийдвэрийн дагуу барилгын зураг төслийг Хууль зүй, дотоод	Эхний хагас жил, жилийн эцэст: Шүүхийн шинжилгээний албаны нэр дээр байгаа газрыг Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн нэр дээр шилжүүлж, барилгын зураг төслийн	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн үйл ажиллагаа явуулж байгаа барилга нь Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь салбар болон Шүүхийн шинжилгээний албаны дансанд бүртгэлтэй тул тус барилгыг актлуулах саналыг 06 дугаар сарын 29-ний өдрийн 01/1205 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, танилцуулсан. Тус барилга Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор	90

1	2	3	4	5	6	7	8
			холбогдох заалт.	хэргийн яамнаас шалгаруулсан гүйцэтгэгч компаниар хийлгэх ажлыг зохион байгуулсан.	холбогдох бичиг баримтыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2023 оны улсын төсөвт суулгуулсан байна.	Шүүхийн шинжилгээний байгууллагаас манай байгууллагад шилжсэнээр газрын асуудал шийдвэрлэгдэнэ. Одоогоор газрын асуудлыг шийдвэрлэсэн тухай холбогдох баримт бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлээгүй тул 2023 оны улсын төсөвт хөрөнгө тусган батлуулах нөхцөл хангагдаагүй.	
Хэсгийн дундаж хувь: 94.3							
Нийт үнэлгээ: 98.2							